

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-31

1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	7-8
2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох	8-31

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Б.Баярсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 21 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Анужин;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Мөнхцэцэг;
Тасалсан: А.Адъяасүрэн, Н.Учрал.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаарт орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын И Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярсайхан: ““Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 9 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Н.Нарангэрэл, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Ш.Алтангэрэл, мөн газрын ахлах мэргэжилтэн Н.Амарбаяр, Ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх инженер Г.Цэрмаа, Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер Д.Алтангэрэл, мөн төвийн Барилга байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтсийн дарга Э.Хангал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Х.Хэрлэн нар байлцав.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Б.Жаргалмаа, Т.Аубакир, Г.Дамдинням, С.Чинзориг, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх инженер Г.Цэрмаа, Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер Д.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонслоо.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
9 цаг 21 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярсайхан: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооноос ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн ирсэн тул ирц бүрдэж хуралдаанаа эхэлье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батална. 2 дугаарт Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батална. 3-д төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсоно. Хуралдаан, юу хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Энэ хэлэлцэх асуудлын 1-д, 2-т байх шиг байна тийм ээ. Энэ Монгол Улсын Их Хурал 23 оны 7 сарын 7-ны өдөр баталсан Боловсролын ерөнхий болон хамт батлагдсан бусад хуулиудад холбогдох тогтоол журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх Ажлын хэсэг гэж. Энэ ямар ажлын хэсэг гарах гээд байгаа билээ? Тэгээд 1-д, 2-т болохоор Улсын Их Хурал чинь хууль тогтоодог, баталсан хуулийнхаа хяналтыг л тавьдаг үүрэгтэй болохоос биш хуулийн хэрэгжилт лүү ороод, тэгээд эрчимжүүлэх тухай асуудал ярих юм бол энэ чинь хууль тогтоох байгууллага гүйцэтгэх засаглалын

хоорондын юу шүү дээ. Энийг яагаад Лхагваа ингээд энд зөвлөдөггүй юм, Их Хурлын Тамгын газраас та нар бас яах ёстой шүү дээ, асууж лавлах ёстой шүү дээ. Хэзээ ингэж хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлдэг ажлын хэсэг ер нь Их Хурлаас гарч байсан юм бэ? Хууль дээр бол юу явж болно. Баталсан хуулийнхаа талаар болбол хяналт мониторинг хийх бүрэн эрх нь болбол Улсын Их Хурал байгаа шүү дээ. Одоо ЗГ юу хийх юм бэ? Яах юм бэ харин тэгээд хэрэгжилтийг эрчимжүүлэх гэж байна шүү дээ энэ дээр. Тэгэхээр ЗГ нь яг юу хийх юм бэ? Эсхүл тэгээд яамнуудаа татан буулгаад Их Хурал нь өөрөө хуулиа хэрэгжүүлээд явах хэрэгтэй шүү дээ. Ийм зарчмын зөрүүтэй ийм томьёолоор тогтоол баталж болохгүй шүү дээ, юутай хуулийн зөрчилтэй.

Б.Баярсайхан: 2024 оны 1 сарын 3-нд Байнгын хороонд Дамдинням гишүүнээс Улсын Их Хурлын гишүүн Дамдиннямаас хүсэлт ирүүлсэн байгаа. Тэгээд энэ талаар Дамдинням гишүүн өөрөө нэг тайлбар өгөх үү?

Г.Дамдинням: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. 2023 оны 7 дугаар сарын 7-нд Монгол Улсын ЗГ-аас өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хууль түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталж, өнгөрсөн 33 жилийн хугацаанд явж ирсэн боловсролын тогтолцооны реформыг хэрэгжүүлэх ийм эрх зүйн томоохон суурь ажил хийгдсэн. Парламент болбол энийг амжилттай баталж гаргасан. Нэлээн ч удаан хэлэлцсэн байх. Миний бие энэ ажлын хэсгийг хуулийг батлуулах ажлыг ахалж ажиллаж байсан. Тэгээд одоо ямар асуудлууд бид нарт гарч ирээд байгаа вэ гэхээр энэ Боловсролын ерөнхий хууль, хамт өргөн мэдүүлээд батлагдсан хуулиуд өөрөөр хэлбэл Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулиудыг дагаад гарах 120 гаруй

журмууд байна. Яамны түвшинд гарна, ЗГ-ын түвшинд гарна, Боловсролын ерөнхий газрын түвшинд гарна. Журмуудтай холбоотой зохицуулалтуудыг бас хуультай нь уялдуулж гаргуулах ажлуудыг бол яам хийгээд явах ёстой нэг. Энэ ажлууд дээр бас Их Хурлаас ажлын хэсэг гарч, ярилцаж чиглүүлж ингээд ажиллаж явах нь зүйтэй гэж 1 дүгээрт үзэж байгаа юм.

2 дугаарт хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх гэдэг үг дээр та бас ярьж байгаа болбол хуулийн хэрэгжилтийг хангуулах талаарх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай гээд үгийг нь сольчихож бас болно. Энд болбол Их Хурал өөрөө хуулийг хэрэгжүүлэх, хангуулах, биелүүлэх энэ ажлыг болбол хийх бүрэн эрхтэй Их Хурлын тухай хуулиараа. Тэгээд энэ дээр яамнууд, сайд нар, ЗГ-ын гишүүд бас нэг их реакцлаад Их Хурлын бүрэн эрхийн асуудалд болбол өөрсдөө хандаад байх боломжгүй. Би энийг бас хууль, эрх зүйн зөвлөгөө авсан, боломжтой. Дарханы зам дээр ч гэсэн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулаад би 3 жил орчим ажиллачихлаа. Ямар нэг хууль, эрх зүйн зөрчил гарсангүй тэнд. Ажил харьцангуй эрчимжсэн, яамд хоорондын зохион байгуулалтыг хангах, Улсын Их Хурлын харьяа байгууллагуудтай ажиллах гээд энэ ажлын хэсэгт болбол их томоохон үр нөлөө байдаг. Тэгэхээр яг энэ жишгээр л ажиллаад явна. Тэгэхээр Их Хурал, ЗГ хамтраад энэ ажлаа хийгээд явчихсан нь зөв гэсэн ийм л байр суурьтай байгаа. Хууль, эрх зүйн хувьд болбол ямар нэгэн зөрчил байхгүй. Өмнө нь ийм ажлын хэсгүүд гарч байсан. Би өөрөө ахлаад ажиллаж байсан.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд тодруулъя.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүн бол ямар ч хууль, тогтоол, санаачлах эрхтэй. Тэрийг бол би хүндэтгэж байна, Улсын Их Хурлын

гишүүний бүрэн эрхийг. Гэхдээ энэ чинь Улсын Их Хурал чинь өөрөө хуулиа батлаад, баталсан хууль дотроо журмаа батална. Энийг, тийм улсын их юу ЗГ сайдын түвшинд ингээд батлах журмууд гээд ингээд түрүүн өөрөө дурдаж байх шиг байна. Энэ журмуудыг бид нар бас ерөнхийдөө бэлдээд эхнээс нь батлуулаад ингээд явж байгаа. Энэ дээр ямар нэгэн тийм Улсын Их Хурал оролцоод байх ерөөсөө шаардлага байхгүй.

2-т нь ерөнхийдөө энэ хуулиар баахан журам баталдаг нэг энэ юунаасаа тогтолцооноосоо ер нь боливол яасан юм бэ? Баахан журмаар зохицуулна, журмаар зохицуулна гэдэг баахан хууль баталдаасаа ер нь боливол яасан юм бэ гэдэг нэг ийм юм ЗГ дээр ер нь ярилцаад, тэгээд энэ Засгийн газраар батлуулах журмууд дээр ер нь зохицуулалтууд хийх ёстой юм байна. Тэгэхгүй бол хуулиасаа илүү журмууд гарч ирчхээд ингээд үл ойлгогдох ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа учраас Хэрэг эрхлэхийн даргаас ахлуулсан ажлын хэсэг гараад, шинээр батлагдсан хуулиудтай холбогдох журмуудыг яг цэгцлэх, цөөлөх энэ ажлын хэсэг бол ингээд ажиллаад явж байгаа. Тэгээд давхар давхардсан баахан ийм ажлын хэсгүүд гарах ерөөсөө тийм онц шаардлага байхгүй л дээ. Хэрэв хуулийн хэрэгжилтийг хангах, энэ дээр дэмжих, туслалцаа үзүүлэх юу байгаа бол Байнгын хороон дээрээ л энэ асуудлуудаа яриад явсан нь дээр шүү дээ.

Б.Баярсайхан: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Ер нь болбол энэ дээр ийм л юм байгаа юм даа. Хуулийн ажлын хэсгийг энэ Байнгын хороо өөрөө Байнгын хорооны тогтоолын төслөөрөө ажлын хэсэг гаргаад л ажиллана. Манай Байнгын хороо боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт гээд 4 салбар хариуцаад явдаг. Тэгэхээр энэ боловсролтой холбоотой асуудлаа бид нар бас

тодорхой ажлын хэсэг гаргаад, парламент өөрөө ажлаа хийгээд явна. Энэ нь зохистой. Салбарын сайд энэ дээр эмзэглээд эсвэл өөр байдлаар хараад байх шаардлагагүй. Бид нар тусдаа дэмтэй нэгтгээд бодлогын хувьд аваад явчихад хуулийн хувьд зөрчил байхгүй, ажлын хувьд ч зөв болно. Их Хурал Байнгын хороо өөрөө өөрийнхөө ажлыг хийгээд явъя. Тэгээд та бүгдтэй бас хамтраад ажиллачихад нэг их болохгүй юм байхгүй л гэсэн ийм л байр суурьтай байгаа. Хууль зөрчих зүйл байхгүй учраас хэлэлцээд, ярилцаад ингээд энэ хэлэлцэх асуудлаа батлаад явчихсан нь зөв байх. Тийм.

Б.Баярсайхан: Тэгвэл хэлэлцэх асуудал дээр юу яая. Та саналаа гаргаад, тэгээд санал хураалгая. Тийм. Өнөөдрийн хуралдаанд, Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналтын газраас мэргэжилтнүүд байгаа учраас нэг тайлбар сонсчихъё, тэгэх үү? 1 номерын микрофоныг өгье.

Ж.Монголжингоо: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тогтоолын үндэслэх хэсэг дээр авсан тэр Их Хурлын 25.6 гэдэг бол зөв эшилж үндэслэсэн байгаа. Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар ЗГ холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай бол Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд тогтоол гаргаж болно гэсэн. Энэ бол тогтоол гаргах тухай байна. Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дээр болохоор Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна гэж байгаа юм. Тэгэхээр тодорхой асуудал гэдэг дээрээ асуудлаа жоохон тодорхой болгоод тогтоолоо гаргачихвал үндэслэж байгаа хэсэг болон тийм тогтоолын хууль зүйн үндэслэл бол зөв байна гэж хэлнэ.

Б.Баярсайхан: Горимын санал гаргах гишүүн байна уу? Яг энэ асуудал дээр санал хураалгая гэсэн. Үгүй болбол хэлэлцэх асуудлаа батлаад, тэгээд хэлэлцэхдээ энийгээ бас яриад явчихъя. Тогтоолын төслөө сайжруулаад. Та микрофон дээр үгээ хэлье.

Л.Энх-Амгалан: Яах вэ Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө сайн бодож болгооно биз дээ. Сая ажлын хэсгийн тэр өгч байгаа тодорхойлолтоор болбол яг ажлын хэсэг гарахад хуультай холбоотой ажлын хэсэг гаргадаг хуулийн зөрчлийг шалган тогтоох ажлын хэсэг гарах юутай гэж байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ хууль дээр зөрчил гараагүй гэж би ойлгож байгаа. Дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа хууль. Тэгэхээр энэ зөрчил гарсан тохиолдолд ажлын хэсэг гарах тэр цагаан дээр хараар биччихсэн тэр юунууд нь байх шиг байна.

2 дугаарт нь болбол тэр тодорхой асуудлаар гэж байна. Одоо яг тодорхой асуудал гэх юм болбол яг ямар асуудлаар гэдгээ тэгвэл тодорхой болгомоор байна шүү дээ. Ингээж байж ажлын хэсэг юу хийх вэ, ямар зорилготой ажлын хэсэг гарч байгаа юм, хүрэх үр дүн нь юу юм, гарах үр дүн нь юу юм гэдэг ийм асуудлуудаар л уг нь ажлын хэсэг байгуулагдаж байвал илүү их үр дүнтэй л болов уу гэж би бодох юм. Тэгээд энэ дээр тэгээд яг хэлэлцэх эсэх дээр нь тэгээд санал хураагаад шийдье. Хэлэлцэх асуудалд орсон асуудлаар гэсэн үг шүү дээ. Тэгээд хойшлуулах гэдэг юм уу, юу ярилцаж бас ойлголцох зөндөө зүйлүүд байна шүү дээ. Тэгээд хойшлуулъя гэсэн юугаар санал хураалт хийе. Ийм саналтай байна. Тийм. Тэгээд хэлэлцэх асуудлаас өнөөдөртөө хасаж, хойшлуулаад ойлголцоод тэгээд дараагийнхаа ажлын хэсгийг байгуулах тэр тогтоолоо дахиж хэлэлцээд явбал яасан юм бэ? Энэ талаар, тийм. Тэгээд энэ дээр нэг гишүүдийг санал хураалгаж өгөөч гэж л би санал гаргаж байна.

Б.Баярсайхан: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Ер нь бол ийм байна. Яах вэ хар аа, Их Хурал Байнгын хороо ямар ч хууль дээр, хэзээ ч батлагдсан бай хэрэгжилтийг нь хангуулах, зөвхөн ганц үндэслэл бол Энх-Амгалан сайд барьж авч яриад байна. Сая энэ 25 дугаар зүйлийн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дээр болбол аливаа бүхий л асуудал дээр Их Хурал, Байнгын хороо ажлын хэсэг гаргаж ажиллах бүрэн эрхтэй. Үндэслэл нь энэ хуулийн үндэслэл байна. Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлд ажиллах бүрэн эрхтэй, туслан дэмжинэ. Тэгэхээр ЗГ-ын гишүүн Байнгын хорооны хуралдаан дээр Байнгын хорооны хийх ажлыг заагаад байх нь зохимжгүй. Бид нар энэ гүйцэтгэх засаглалын ажилд дэмнэе, тусалъя, Боловсролын ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг хэлэлцүүлъя, араас нь хөөцөлдөөд явъя. Их Хурлын зүгээс дэмжих туслах зүйл юу байна, болж байгаа, бүтэхгүй байгаа асуудлууд байгаа бол яриад явъя гэж. Надад болбол үндэслэлүүд бас байна. Би хэлэлцээд явахаар нь хэлье гэж бодоод энд нөөцлөөд байж байна. Тэгэхээр эхлээд эхлээд хэдүүлээ энийгээ хэлэлцэх асуудлаа яриад, тэгээд саналаа хураагаад явчихъя. Болохгүй гэвэл болохгүй л байя тийм. Тэгэх үү? Тийм.

Одоо ингээд бид нар хар аа, та нар нэг юмыг ойлгоорой. Одоо бид нар ажлын хэсгээ байгуулаад, энэ чуулган завсарласан хугацаанд ажиллаад, ирэх чуулган эхлэхэд ажлын хэсгийнхээ удирдамжтайгаа, тайлантайгаа уулзаад Байнгын хороогоороо хэлэлцүүлээд явахгүй болбол нэг чуулган. Энх-Амгалан сайд аа, Энх-Амгалан сайд аа, би үг хэлж байна. Би үг хэлж байна. Та ЗГ-ын гишүүн Их Хурлын гишүүний ажлаа хийх юманд битгий оролцоод бай л даа. Би ажлаа хийгээд л, яриад явж байна тэгэх үү. Энэ бүрэн эрх, Их Хурлын бүрэн эрх, Их Хурлын гишүүний бүрэн

эрх, тэгээд тийм байгаа. Тийм юм байхгүй, байхгүй. Тэгэхээр хэдүүлээ хэлэлцэхээрээ хэлэлцээд л явчихъя тэгэх үү? Тийм.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдын гаргасан горимын саналаар өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын 2-т байгаа Ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулъя гэсэн үндэслэлээр, саналаар санал хураалт явуулъя. Юу яагаад, одоо яадаг юм билээ дээ, дэмждэг юм билээ, тийм ээ. Та 2 гоё ярилцаад юу хугацаагаа яачих. 5 гишүүн энэ асуудлыг хойшлуулахыг дэмжсэн учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа.

Нэг. ““Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Тэгээд энэ тогтоолын төсөл, уучлаарай хурлаа үргэлжлүүлъя. Энх-Амгалан сайд аа, одоо юу яачихсан сая санал хураалт явагдаад, шийдэгдчихсэн. Тэгэхээр өнөөдөр хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл дээр Дамдинням гишүүн ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Дамдиннямыг нэмж, ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд зарим өөрчлөлтийг оруулсан байгаа.

Тэгэхээр Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн

төсөл. Санал хураалт. Үгүй ээ энэ чинь энэ дээр дараад л. Энэ дээр дараад л, энэ дээр дарах нь зөв биз дээ. 75-аар, 75 хувиар санал хураалт дэмжигдсэн. Хэн өөрийнхөө юуг яачхаж байгаа юм уу. Үгүй ээ тэгээд зүгээр юугаа сонсчихъё л доо. Тийм. Танилцуулга сонсож болно. Бид нар санал хураахгүй, санал хураалт байхгүй.

9.44 цаг

Хоёр.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандартад шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Улсын Их Хурлын гишүүн Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан танилцуулна уу.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Гишүүд ээ ийм байгаа энэ төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангах энэ ажлын мэдээллийг өнөөдөр Байнгын хороондоо хийхээр бэлдсэн байгаа. Энэ 3 дахь удаагийн, бараг 4 дэх удаагийн мэдээлэл байх Байнгын хороон дээрээ хийж байгаа. Гэхдээ энийг жаахан товчлоод та бүгдийг зөвшөөрвөл жаахан товчлоод хийчихье гэж бодож байна. Тэгээд ерөнхийдөө нөгөө нэг бүх 4 ийм төслийн үе шаттайгаар энэ төсөл хэрэгжиж байгаа юм. Тэгээд бүх аймгууд дээр хэрэгжиж байгаа төслүүдийг бид нар бүүр нэг бүрчлэн энэ мэдээллүүдийг энэ тухайн сонгогдсон аймгуудын гишүүдэд хүргүүлсэн учраас

энэ мэдээллээ жаахан товчлоод хийчихье. Хэрэв та бүгдийг зөвшөөрөөд бодвол. Тийм.

Монгол Улсын ЗГ-ын 20-оос 24 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.3.9.4-д боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох зорилтыг тусгасан. Монгол Улсын Их Хурлын 20 оны 39 дүгээр тогтоолоор Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газрын 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн ЗГ-ын 21 оны 127 дугаар тогтоолын дагуу төсөл, арга хэмжээг эхлүүлэн 4 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. ЗГ-ын 23 оны 266 дугаар тогтоолын хүрээнд Эрдэнэс Монгол ХХ компанийн ТУЗ 23 оны 12 сарын 8-ны өдөр хуралдаж тус ТУЗ-ийн 23 оны 95 дугаар тогтоолоор Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газрын 24 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний 2 дугаар хавсралтаар уг төслийг бүрэн дуусгахад шаардагдах нэмэлт 60 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж баталсан.

Энэ дээр энэ нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих энэ санал санаачилгыг бол манай Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн санаачилгаар хэрэгжиж байгаа ийм төсөл байгаа юм. Тэгээд шаардлагатай нэмэлт жаран, 60 тэрбум төгрөгийг батлаад нийт 160 тэрбум төгрөгөөр нийт 820 орчим сургууль, цэцэрлэг, дотуур байрны энэ юуны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжид шилжүүлэх энэ ажлууд хийж байна. Тийм учраас болбол би бас яг энэ ажлыг санаачилсан нийт Их Хурлын эмэгтэй гишүүд, тэр дотроос энэ төслийг санхүүжүүлж хэрэгжүүлж байгаа Эрдэнэт үйлдвэрийн хамт олонд бас гүн талархал илэрхийлье гэж бас бодож байна.

Энэхүү төсөл, арга хэмжээний хүрээнд Монгол Улсын хэмжээнд 233 цэцэрлэг, ерөнхий боловсролын 337 сургууль, 250 дотуур байр орчин үеийн байгууламжтай болно. Нийт 17 аймгийн 297 сумд төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын 3 цэцэрлэг тутмын 1-д, ерөнхий боловсролын 2 сургууль тутмын 1-д энэхүү төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Төслийг 4 ээлжтэйгээр хэрэгжүүлж байгаа. Тэгээд 4 ээлжийн явцын үр дүнгийн талаар товч, товч мэдээлэл өгье гэж бодож байна.

Төслийн 1 дүгээр ээлжийн явц үр дүн түлхүүр гардуулах нөхцөлт гэрээтэйгээр хэрэгжиж буй 1 дүгээр ээлжид 16 аймгийн 50 сумын 172 объектод ажил хийлгэхээр гэрээлэгдсэнээс 116 объект ашиглалтад орсон. 8 объектыг байнгын ашиглалтад оруулах, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангасан боловч хөдөө орон нутагт цас их унасан байхаас шалтгаалж комисс ажиллуулж чадаагүй хүлээгдэж байна. Үлдсэн 48 объектын угсралтын ажлын явц 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төслийн 2 дугаар ээлжийн ээлжид мөн түлхүүр гардуулах нөхцөл гэрээтэйгээр хэрэгжүүлж буй 2, хэрэгжүүлж буй энэ ажлын хүрээнд 15 аймгийн 42 сумын 135 объектод ажил гэрээлэгдсэнээс 125 объект ашиглалтад орсон, 2 сумын 10 объектыг байнгын ашиглалтад оруулах, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангасан боловч хөдөө орон нутагт цас их унасан байгаагаас шалтгаалж комисс ажиллуулж чадахгүй чадаагүй хүлээж байна. Ингэснээр 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил бүрэн дуусаад байна.

Төслийн 3 дугаар ээлжид 17 аймгийн 130 сумын 330 объектын жагсаалтыг баталж, эдгээр объектын зураг төсвийн ажлыг давхардсан тоогоор 7 компани шалгарч гүйцэтгэж

байна. Өнөөдрийн байдлаар 14 аймгийн 100 сумын 262 объектын ажлын зураг төсөв дуусаж, магадлангийн дүгнэлт гарсан. Ажлын зургийг аймагтай зөвшилцөх, магадлал хийх түвшинд 3 аймгийн 27 сумын 68 объектын зураг төсөв байна. Зураг төсөв гүйцэтгэх явцад хийгдсэн судалгааны үндсэн дээр 3 ээлжид 27 объект нэмэгдсэн болно. Магадлал бүрэн гарсан ажлын зураг төсвөөр угсралтын ажлыг гүйцэтгүүлэх худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулж Баян-Өлгий, Архангай, Хэнтий, Булган, Ховд, Сэлэнгэ, Дундговь, Өвөрхангай аймгуудад бүрэн, Увс аймгийн 6 сум, Сүхбаатар аймгийн 4 сумд гүйцэтгэгч шалгарч, ажил гүйцэтгэж явц 40 хувьтай үргэлжилж байна. Дээрх аймгийн угсралтын ажлыг 15 ААН гүйцэтгэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар эхний ажлууд дуусаж, Архангай аймгийн Өлзийт, Өгий нуур, Төвширүүлэх, Эрдэнмандал зэрэг 4 сумын 10 объект, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нэг объектод байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллаж ажилласан байна. Увс аймгийн 5 сум, Сүхбаатар аймгийн 3 сумын болон Дорноговь, Дорнод, Говь-Алтай, Баянхонгор аймгийн объектуудад угсралтын ажлыг гүйцэтгэх худалдан авах ажиллагаа үргэлжилж байна.

Төслийн 4 дүгээр явцад 18 аймгийн 92 сумын 243 объектыг хамруулахаар зураг төсвийн, зураг төсвийн зөвлөх үйлчилгээ зарлаж дэлгэрэнгүй болон хураангуй гэсэн 2 үе шаттайгаар худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 10 ААН шалгарч ажлын зураг төсөв хийгдэж байна. Үүнд Өвөрхангай, Завхан, Увс, Хөвсгөл, Архангай аймгийн зураг төсвийн магадлалын дүгнэлт гаргаж, угсралтын ажлын худалдан авалт дахь үйл ажиллагааг зохион байгуулж байна. Дорнод, Сүхбаатар аймгийн ажлын зураг төсөвт магадлал хийгдэж, салбар экспертүүд дүгнэлтээ гаргасан. Төсвийн эксперт хянаж байна. Төслийн 4 дүгээр ээлжид аймгуудаас ирсэн саналд

тулгуурлан 243 объектод ажил хийгдэхээр жагсаалт батлагдсан бөгөөд зураг төсөв хийх судалгааны явцад актлагдсан байр, шинээр ашиглалтад орж буй барилга байгууламжид ариун цэврийн байгууламж хийхээр төлөвлөснөөс тоо хэмжээ буурах төлөв ажиглагдаж байна.

Төслийн явц, үр дүнг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд өмнө нь 3 удаа танилцуулж, зөвлөмж чиглэл авч ажиллаж байна. Төслийн 1 болон 2 дугаар ээлжийн 307 объектын гүйцэтгэгчийг түлхүүр гардуулах гэрээтэйгээр хэрэгжүүлсний улмаас ажлын гүйцэтгэх хугацаа, технологийн шийдэлд хундрэлүүд гарсан. Энэхүү нөхцөл байдалд дүгнэлт хийж, зураг төсвийг эхэлж нөхөж хийлгэснээр өнөөдрийн байдлаар 3 дугаар ээлжийн зураг, 3 дугаар ээлжийн угсралтын ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, одоогоор 2 аймгийн 5 объектууд ашиглалтад орж, 10 аймагт ажил эхлүүлсэн байна. Санхүүжилтийн талаар 23 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зураг төсөвт 2,8 тэрбум төгрөг, угсралтын ажилд гүйцэтгэлээр нь 58 аравны, 58 тэрбум төгрөг нийт 60 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргасан. Эхний 100 тэрбумын үндсэндээ ажлын бүх тендерүүд зарлагдсан, зарлагдсан байгаа. Одоо ингээд нэмж батлагдаж байгаа 60 тэрбумын ажлууд нөгөө зураг нь дуусаж байгаа 3, 4 дүгээр ээлжийн ажлуудын худалдан авалт дахь, юу гүйцэтгэх ажлуудын тендерүүд зарлагдаж байна гэдэг мэдээллийг Байнгын хороонд хийж байна. Анхаарал тавьсан гишүүддээ баярлалаа.

Б.Баярсайхан: Сайдын мэдээллийг сонслоо. Улсын Их Хурлын БСШУС-ын байнгын хорооны 2021 оны 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт

шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газраар шийдвэрлүүлэн 2021-ээс 2022 онд багтаан хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулах, ажлын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг бас энэ сүүлийн 3 жил ингээд ажиллаад явж байгаа. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ануужин, Баатарбилэг, Жаргалмаа, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Өнөрболор, Ундрам, Энхтүвшин нар ажиллаж байгаа.

Өнөөдрийн хуралдаанд дэд ажлын хэсгийг төлөөлж салбарын сайд Энх-Амгалан, боловсрол ерөнхий, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг, БШУЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Нарангэрэл, БШУЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Тамираа, Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалт, хэрэгжилт зохицуулалтын газрын дарга Алтангэрэл, Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Амарбаяр, Боловсролын ерөнхий газрын Ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх инженер Цэрмаа, Барилгын Хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хэлтсийн дарга Амарсанаа, Барилгын хөгжлийн төвийн Амарсанаа дарга ирсэн үү? Амарсанаа дарга ирээгүй байна. Энэ саяын нэр дурдагдсан хүмүүс бүгд ирсэн биз дээ? Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хэлтсийн дарга Мөнхсүх, ирсэн үү? Энэ Барилгын хөгжлийн төвийнхөн яагаад энэ Байнгын хорооны хурал таслаад байгаа юм. Ням-Очир дарга дэд ажлын хэсгийнхээ хүмүүсийг бүрэн бүрэлдэхүүнээр нь авчиръя. Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн зураг төслийн

магадлалын хэлтсийн дарга Хангал. Ийм хүмүүс өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

Ер нь болбол салбарын сайд бол сая энэ бүтээн байгуулалтыг хийхэд тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээл гарсан учраас хугацаа хоцроод явж байгаа талаар ярилаа. Гэхдээ 2024 оны 6 сард Засгийн газар, Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусах гэж байна. Өнөөдөр маш олон аймгуудаар өвөлжилт нийт нутгийн 80 хувьд нь өвөлжилт хүндэрч байна. Хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдийн амьдрах, сурах орчин хүнд хэвээр байсаар байна. Тийм учраас энэ асуудал болбол Монгол Улсын хэмжээнд нөгөө төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутагтаа хот хөдөөгийн ялгарал арилж, хэнийг ч орхигдуулахгүй байх, хүний эрхийн асуудал, хүүхдийн эрхийн асуудлын хүрээнд хийгдэж байгаа Монгол Улсын хэмжээнд анх удаа хийгдэж байгаа ийм том бүтээн байгуулалтын ажил юм. Тэгэхээр салбарын сайдын мэдээлэлтэй холбогдуулж гишүүдийг, асуулт асуух гишүүн гишүүдийн нэрсийг авъя. Ер нь бол энэ ажил өнөөдөр чуулган завсарлаад Улсын Их Хурлын гишүүд, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт үйл ажиллагааны хөтөлбөрт туссан энэ том бүтээн байгуулалтыг өөрийн сонгогдсон тойрог нутагт шалгах энэ ажлыг бас хийгээсэй гэсэн үүднээс өнөөдөр бүх Улсын Их Хурлын гишүүдэд яг өнөөдрийн энэ танилцуулагдаж байгаа явц байдлын талаарх мэдээллүүдийг бас явуулсан байгаа. Ингээд асуулт асуух гишүүн байна уу? Энх-Амгалан гишүүнээр тасалъя. Тэгээд тэрийг нь яагаагүй явчихъя. Ундрам гишүүнд микрофоныг өгье.

Ч.Ундрам: Энэ Монгол Улсын 21 аймагт байгаа энэ нүхэн жорлонгийн асуудал бол Монгол Улсын хамгийн том эмгэнэлүүдийн нэг юм. Тэгээд энийг бол ер нь бол манай эмэгтэй гишүүд тэр дундаа өмнө нь энэ Дэлхийн зөн, Мобиком болон Боловсролын яам энэ ажлыг анх

эхлүүлсэн байдаг ийм түүхтэй. Энийг бол бүгд мэдэж байх ёстой гэж би боддог. Ингээд Боловсролын яам эхлүүлж байгаад энэ дээр шаардлагатай санхүүжилтийг нэг мөр улс анхаарч ингэж том төсөл хөтөлбөр болгож хэрэгжүүлж байгаа нь бол маш том асуудлыг шийдэж байгаа гэж харж байгаа. Энэний цаана хүүхдийн эрүүл мэндийн асуудал, насан туршийн гепатит вирус, гэдэсний суулгац, ханиад томуу бол наад захын асуудал. Халтирч, даардаг асуудал, хүчирхийлэл тэнд явагдаж байдаг гээд маш олон асуудлыг шийдэж байгаа ийм том төсөл хөтөлбөрийг бид нар өнөөдөр ярьж байгаа. Тэгээд энэ дээр бол яах аргагүй эмэгтэй гишүүд энэ асуудлыг харсан, эмэгтэй хүн гэдэг утгаараа гэж би бодож байгаа. Тэр дундаа энэ мөнгө төгрөгийг олж ирэх гарц гаргалгааг хайх ажил дээр Баярсайхан гишүүн бид 2 бол үнэхээр энэ дээр зүтгэж, гаргалгаа гаргаж, манай эмэгтэй гишүүд бүгд дэмжиж, хамтдаа зүтгэж байж энэ асуудлыг өнөөдөр бид нар ийм 4 үе шаттай хэлэлцэх хэмжээнд улс орон даяар ярих хэмжээнд хүрч байгааг хэлэх ёстой гэж үзэж байгаа юм.

Тэгээд хэд хэдэн бас асуулт байна. 1 дүгээрт энэ бүх аймгаар нь гаргачихсан байна. Тэгээд энэ манай энэ Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар сургуультай холбоотой надад нэг албан бичиг ирсэн байгаа. Тэгээд энэ өмнө нь Дэлхийн Зөн, Мобиком, Боловсролын Яамны гуравласан гэрээний хүрээнд хийгдсэн нүхэн жорлон боловчиг бохирын систем нь одоо бас ингээд аягүй өндөр зардалтай соруулдаг ийм байдалтай байгаад байна. Иймэрхүү нөхцөл байдалтай сургуулиудыг энэ төсөлд ганихан сургууль байна л даа манай аймгийн хувьд, хамруулчих ийм боломж байдаг уу? Бохирыг нь орчин үеийн тэр септик технологи гээд бид нарын хийгээд байгаа энэ технологи руу оруулах боломж байна уу гэсэн ийм албан бичиг ирсэн байгаа.

2 дугаарт энэ та бүх бүхний тайланд ирүүлсэн энэ Сэлэнгэ аймгийн Ерөө сум дээр ЕБС-ийн хуучин сургуулийнх нь бие засах газар нь бас ингээд нүхэн жорлонтой. Энийг оруулна гээд яачихсан байгаа мөртөө гүйцэтгэл дээр нь тэг гээд энэ тайлан дээр байна л даа. Энэ ямар учиртай юм бол гэж ийм асуулт.

Мөн маш олон сургуулиуд бас өнөөдрийг хүртэл бас 1 дүгээр ээлжийн зарим сургуулиуд, тэгээд 3, 4 дүгээр ээлжийн сургуулиудын нүхэн жорлон арай дуусаагүй, гүйцэтгэл нь 100 хувьд хүрээгүй байна л даа. Жишээлбэл Төв аймаг 38 нүхэн жорлон, 38 объект нүхэн жорлонтой юм байна. Тэгээд эндээс зөвхөн 6 объект л орчихсон байгаад байдаг. Үлдсэн энэ 17 3 дугаар ээлжийн, 4 дүгээр ээлжийн 13 гээд 60, 30 хувьтай явж байна. Энэ яг хэзээ гэхэд бүрэн болох вэ? Энэ өвлийн хүйтэн үед мэдээж барилгын ажил явах боломжгүй. Гэтэл тэнд чинь хүүхдүүд бас л гадаа нүхэн жорлонд бие засаад л өвчин ханиад томуу тусаад байж байгаа. Тэгэхээр энэ дээр бас яг ийм тодорхой хугацаа сонсмоор байна.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ундрам гишүүнд баярлалаа. Тэгээд бас ер нь Ундрам гишүүн, Баярсайхан гишүүн 2-ыг бас онцлох ёстой. Энэ бол энэ ажлыг анхнаас нь санаачлах, санхүүжилтийн эх үүсвэрүүдийн олох энэ шийдлүүд гарах, ингээд хамгийн гол нь хэрэгжилт дээр нь Улсын Их Хурлаас ажлын хэсэг гараад ингээд Баярсайхан гишүүн өнөөдөр Байнгын хорооны дарга бас ахлаад ингээд явж байгаа. Энэ дээр бол туйлын бид нар талархах ёстой энэ 2 гишүүнд.

2-т нь болбол Ундрам гишүүнээ тэр нөгөө Мобиком, Дэлхийн Зөн энэ тэрээр хийгдэж байсан өмнө нь хийгдээд нэг жаахан ашиглалт муутай байгаа энэ тэр объектуудыг бид нар шинэчилнэ.

Тийм учраас бол сая таны хэлсэн тэр сум дээр Ням-Очир дарга тэр сумын асуудал, Алтангэрэл дарга тэр сумын асуудлыг бид нар бүрэн шийдвэрлэж энэ хүрээндээ ажлынхаа хэсэгтээ ороод, тэгээд шинээр зураг хийгдэх ёстой тийм тэр саналуудаа өгчих. Ер нь болбол асуудал яг юун дээр энэ та нөгөө 3, 4 дүгээр ээлжийн нөгөө энэ юу хэрэгжилт яагаад удааширалтай байгаад байгаа юм гэдэг асуудал яриад байх шиг байна. Хамгийн гол нь энэ нөгөө нэг мордохын хазгай болсон гэдэг чинь анхнаасаа 1, 2 дугаар ээлж чинь зураг төсөлгүй зарлагдчихсан байхгүй юу. Түлхүүр хүлээлгэх юутайгаар. Тийм учраас болбол үндсэндээ нөгөө нэг зураг төсөлгүй зарлагдсан юунууд бол хэрэгжилтийн явцад маш их асуудлууд гарсан. Энийгээ бид нар ер нь нөхөж, энэ алдаагаа засаж 1, 2 дугаар ээлжийн зураг төсөлгүй зарлагдсан бүх объект дээр нөхөж бид нар зураг төсөл хийсэн. Тэгээд 3, 4 дүгээр ээлжийнхийг болбол бид нар бүгдийг нь зураг төслийг нь эхэлж хийгээд, зураг төсөлтэй тендер зарлагдаж байгаа учраас энэний гүйцэтгэл дээр болбол том эрсдэл гарахгүй болов уу гэж би бодож байна.

Сая таны хэлсэн Төв аймаг тийм ээ, ингээд Дарханд, Дарханы хөдөөгийн сумууд, Сэлэнгийн сумуудтай холбоотой энэ таны бүсчилсэн том тойрогтой холбоотой энэ аймгууд, ийм сумуудын асуудлууд дээр бид нар нэг бүрчлэн энэ гүйцэтгэлүүдийг бол хянаад, тодорхой үр дүнгүүд гаргаад. Ер нь бол бид нар нэг зүйлийг л хариуцлагатай хэлнэ. Би бас өнгөрсөн намар энэ Байнгын хороо, Улсын Их Хурлын чуулган дээр хэлж байсан. Энэ төслийг амжилттай хэрэгжүүлэхэд салбарын сайдын хувьд хар толгойгоороо хариуцна гэдэг ийм амлалт өгч байсан. Тэгээд энэ дээр болбол бид нар өнөөдөр ямар нэгэн байдлаар нэг тийм шалтаг шалтгаан ярих ямар ч шаардлага байхгүй. Тийм учраас болбол энэ 24 оны 20-оос 24 оны 3Г-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад

болбол бид нар онцгойлон анхаарч ажиллана. Тэгээд ирэх хавар гэхэд болбол бид нар үлдсэн энэ сургууль, цэцэрлэг, дотуур байрныхаа ариун цэврийн байгууламжуудыг бүрэн шийдэх ийм бололцоотой байгаа.

Б.Баярсайхан: Жаргалмаа гишүүнд микрофон өгье.

Б.Жаргалмаа: Өглөөний амгаланг айлтгая. Үнэхээр ЕБС-ийн хүүхдүүдийн хэрэглэж байгаа сургууль, цэцэрлэг болон дотуур байрны асуудлыг бид бас шийдвэрлэх тал дээр онцгойлон анхаарч Улсын Их Хурал, Монгол Улсын ЗГ, тэр дундаа Эрдэнэт үйлдвэр санхүүжилтийг шийдээд томоохон ажил хийгдэж байгаагийн явцыг бид нар сонсож байна. Үнэхээр яг энэ ажлыг эхлүүлэхэд бид нар ер нь тухайн газар орон нутгаас шалтгаалан технологийн хувьд ямар байх вэ гэдгийг бас салбар салбарын инженерүүдтэй уулзаж ярилцаж, энэ барилгын салбар тэр дундаа энэ технологийн салбарт амжилттай яваа компаниудтай уулзаж бол маш их ярилцаж байж уг нь асуудлыг шийдсэн. Гэсэн хэдий ч сайдын хэлдгээр нөгөө мордохын хазгай гэгчээр 1 дүгээр ээлжийн ажил бол маш удааширалтай ер нь болбол маш их гацсан байдалтайгаар явсан. Технологи буруу сонгосноос шалтгаалан гүйцэтгэсэн ажил үр дүнгүй байх гэдэг юм уу, зураг төсөв хийгдээгүйгээс ажил эхэлснээс шалтгаалан шугам хоолойн асуудал дутуу тавигдсанаас төсөв мөнгө дахин нэмэгдсэн ч гэдэг юм уу энэ мэт олон асуудал үүссэн.

Эрдэнэт үйлдвэр дахиад 60 тэрбумыг бас бидэнд бас өгч, энэ хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэ гэдэг ийм боломжийг олгож байгаад бас талархлаа илэрхийлье. Ер нь бол бидний ажил маш удаан явж байгаа. Бүтэн 3 жил өнгөрчхөөд байхад чинь бид нар эхний ээлжийн ажлыг гэхэд л 88 хувийн гүйцэтгэлтэй байна гэдэг бол үнэхээр харамсалтай. Бид хүүхдүүдийнхээ эрүүл

мэндийн асуудлыг, аюулгүй байдлын асуудлыг бас шийдвэрлэх нь гарц нэг нь гэдэг үүднээс энэ ариун цэврийн байгууламж жорлонг нь сольё гэдэг энэ ажлыг эхлүүлж байсан. Гэтэл үнэхээр хангалттай бус байна л даа. Яг 1 дүгээр ээлжийн ажил 88 хувь гэхээр яг үнэхээр ажил эхлэхэд тухай тийм байсан. 2 дугаар ээлжийн ажил барилга угсралтын ажил бүрэн дууссан гэдэг бол таатай мэдээ. 3 дугаар ээлжид ч гэсэн хэд хэдэн объект бас дутуу 40 хувийн гүйцэтгэлтэй байна гэдэг ийм тоо баримт байна л даа.

Зүгээр яг одоо ингээд барилга угсралтын ажил хийгээд, улсын комисс хүлээж аваад, ажил гүйцэтгээд явахаар тухайн ариун цэврийн байгууламжийн гэдэг юм уу нөгөө гүйцэтгэх хариуцах эзний асуудал бас тухайн үед яригдаж байсан л даа. Энэ асуудал яг өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдэж чадсан уу? Өөрөөр хэлэх юм бол септек байдаг юм уу, соруулах технологи юу байдаг юм технологиор явлаа гэхэд тухайн сургууль өөрөө түүнийгээ хариуцаад явах зардал мөнгөний асуудал байхгүй. Орон нутаг нь хариуцах уу, хэн хариуцах вэ? Гүйцэтгэсэн компани хариуцах уу, хэн хариуцах вэ гэдэг юм уу маш олон ийм асуудлууд үүсэж байсан. Энэ дээр ер нь ямар арга хэмжээ авсан бэ? Ямар нэгэн шийдлийг олсон уу?

Нөгөөтээгүүр тухайн зураг төсвийн тендер зарлаад, тэр тендерт оролцоод, ААН-үүд нь ажил гүйцэтгэх гээд явж байхад 800 метрийн шугам хоолой дутуу тооцоолсон байна гэдэг юм уу, тухайн ААН-ээс шалтгаалсан ийм буруу тооцоолол байсан. Энэ тооцооллын хариуцлагыг нь ямар нэгэн байдлаар шийдвэрлэж чадсан уу, хариуцлагыг нь хэн хүлээсэн бэ? Өөрөөр хэлэх юм бол буруу зураг төсөв гаргасан, зураг тооцооллоо буруу хийснээс шалтгаалан гүйцэтгэгч компанид хариуцлага тооцож байна уу, захиалагч хариуцлага хүлээж байна уу? Энэ дээр бас нэг юм хэлээч, мэдээлэл өгөөч. Би

яагаад ингэж асуугаад байна вэ гэвэл энэ зарцуулалтыг, төрийн мөнгийг бид нар үргүй зармааргүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн хариуцлага өгч, тооцсон уу гэдэг зүйлийг асууя.

Энэ орон нутаг, алслагдсан сум орон нутгийн сургуулиуд ер нь нэг гээгдэх гээд байна гэдэг нэг зүйл ярьсан л даа. Би тэгээд зүгээр нөгөө л мэддэгээрээ Увс аймгийн Зүүнхангайн сумаа харлаа. Ганц сургуулийн асуудал шийдэгдэж байгаа юм байна бас гүйцэтгэл нь 40 хувьтай хангалттай дуусаагүй л байгаа гэсэн байна л даа, 2 дугаар ээлжид орчихсон юм шиг байна. Тэгэхээр энэ мэт ажлуудыг хэдийд дуусгах вэ? Одоо бид нарын бүрэн эрхийн хугацаа ерөнхийдөө дуусаж байна. Энэ хугацаанд бид нар хяналт тавиад, эргээд ажлыг эрчимжүүлэх, энэ хариуцлагын асуудлыг чангатгах тийм боломж байна уу, үгүй юү гэдгийг би бас сайдаас тодруулъя.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдын хариултыг сонсъя, микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Жаргалмаа гишүүнээ ерөнхийдөө ажил удааширсан уу гэвэл удааширсан. Энэтэй бол бид нар бүгдээрээ яах ёстой, хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ энэ дээр одоо би нэг их тийм шалтаг тоочмооргүй байна. Өмнөх, хойдхыг яриад л, тэгээд анхнаасаа ингэсэн, дунд нь ингэсэн гээд. Тэгээд мэдээж ковид ярих юм бол энэ чинь бараг үндсэндээ яг барилга угсралтын ажил бол сүүлийн 2 жил л жаахан эрчимтэй явагдаж байгаа л ажил шүү дээ тийм ээ. Тендер яг энэ төсөл хэрэгжээд яг хэрэгжиж эхлэх гээд төсөв батлагдах гээд, тэгээд баахан нэг зураг төсөлгүй тендерүүд зарлагдаад, тэр нь ковидтой залгаад, ингээд нэг ийм би түрүүн бас хэлсэн нэг мордохын хазгай болсон гэдэг шиг нэг ийм зүйл болсон. Гэхдээ ямар ч байсан бид нарын хариуцлага болбол энэ төслийг 100 хувь л

хэрэгжүүлэх ёстой, 100 хувь хэрэгжүүлж дуусах ёстой.

Тэгэхээр бид нарын өмнө гарсан энэ бүх алдаа дутагдлуудаа бид нар өнөөдөр зассан гэдгийг бол хариуцлагатайгаар хэлчихье. Одоо болбол ямар нэгэн тийм зураг төслөөс шалтгаалаад эсхүл гүйцэтгэлээс шалтгаалаад, бүүр том тэр компани нь дампуурчихдаггүй л юм болбол ийм том эрсдэл болбол би харахгүй байна гэж бодож байгаа. Зүгээр энэ дээр нэг хэд хэдэн гол асуудал гарч байгаа нь энэ хөрстэй холбоотой асуудлууд бас их, бид нарын урьдчилж тооцоолоогүй асуудлууд гарч ирж байна. Цэвдэг, цэвдэгтэй сумууд гарч ирж байгаа. Тэгэхээр энэ цэвдэгтэй сумууд дээр бид нар нөхөж зураг хийж байгаа учраас тэр цэвдэгтэй сумууд дээр байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байруудын хэрэгжилт болбол 3, 4 дүгээр шат руу орсон. Тэгэхээр нөгөө 3, 4 дүгээр шат гэдгийг та нар нөгөө арай жаахан хэрэгжилт удаан байна, явц нь 30, 20, 30 хувьтай яагаад ингээд байгаа юм бэ гэхээр энэ нөгөө зураг хийгдэж байгаа байхгүй юу. Тэрнээс биш яг бодитой нөгөө барилга угсралтын ажлууд нь хийгдэж эхлээгүй гэсэн үг шүү дээ. Зураг төслүүд нь дуусаад, одоо үндсэндээ дуусаж байгаа. Тэгээд зураг төсөл дээр үндэслэж нөгөө тендер, гүйцэтгэгч шалгардаг учраас бол нэг гүйцэтгэлийн явц нэг ийм маягтай харагдаж байж магадгүй.

Би нэг зүйлийг хэлье. Одоо яг ашиглалтад орчихсон байгаа 302 байна уу, 302 улсын комисст өгчихсөн байгаа объектуудаас өнөөдөр яг ажиллахгүй байгаа тийм ээ, технологио буруу сонгоод эсхүл захиалагч тэр сургууль, дотуур байруудын үйл ажиллагаанаас болоод ажиллахгүй болчихсон өнөөдөр нэг ч объект байхгүй, нэг ч объект байхгүй. Энийг бол би хариуцлагатайгаар хэлье. Хамгийн гол асуудлууд болбол юу гарсан гэхээр 1 дүгээрт тэр цэвдгийн асуудал. 2 дугаар асуудал болбол яг энэ аймаг, орон нутаг,

сумуудын сургуулиудын удирдлагын жаахан сэтгэлгүй байдлаас болж, тэр нөгөө байршлууд их хөдлөөд байгаа юм. Энд барина, энд баримаар байна гээд ингээд хэлдэг. Нөгөө талаасаа болбол яг энэ ариун цэврийн байгууламжуудыг байршуулах тэр байртай холбоотой асуудлууд байгаа байхгүй юу. Зарим нь ингээд актад акталчихсан байшингаа хүртэл өгч байгаа байхгүй юу. Тэгээд юу гэдэг юм яг газар дээр нь очоод үзэхээр яг тэр ариун цэврийн байгууламжууд байгуулах ямар ч боломжгүй.

Тийм учраас болбол зарим тохиолдолд зарим сум дээр бол бид нар сургууль дээр нь, дотуур байр дээр нь, спорт заал дээр нь өргөтгөл хийж байж энэ ариун цэврийн байгууламжуудыг хийж байгаа. Тэгэхээр энэ ариун цэврийн байгууламж харахад яах вэ хүний нүдэнд нэг юм газарт юм булаад, ингээд нэг хэдэн сантехникийн труба хооронд нь холбоцхож байгаа асуудал биш л дээ. Энэ чинь ингээд барилгын ийм цогц ажлууд хийгдэж байгаа юм байна лээ. Та бүхэн бүгд газар дээр нь очиж бас үзсэн. Энэ чинь барилга угсралтын ажил явагдаж байна, сантехникийн ажлууд явагдаж байна тийм ээ. Ингээд дулааны гэдэг юм уу, цэвэр бохирын асуудлууд хамтдаа ингээд шийдэгдээд явж байгаа. Бохирын асуудлууд нь ингээд явж байгаа, яг цэвэр инженерингийн иж бүрэн шийдлээр хийгдэж байгаа ажлууд учраас энэ дээр болбол тухайн объект бүрээс, тухайн газар нутаг байршилаас шалтгаалж ийм тодорхой хүндрэлүүд гарч байгаа. Тийм учраас болбол яг хэрэгжилтийн явцад хүндрэл байгаа. Компаниуд дээр, зарим нэг компаниуд дээр үнэхээр хариуцлага алдсан явдлууд байгаа. Энийг бол бид нар хэдэн компанийн гэрээ цуцалсан юу байгаа билүү? Байгаа тийм ээ. Тэр яг нөгөө аль, аль аймгууд дээр яг ямар, ямар нөхцөл байдлууд гараад, хэдэн компанийн гэрээ цуцлагдаад, тэгээд саяын тодруулаад тэр нөгөө Увсын сумуудыг ярих шиг боллоо. Энэ дээр миний хариулт дээр тодруулаад Ням-Очир дарга илүү дэлгэрэнгүй хариулт өгчих тэгэх үү.

Б.Баярсайхан: 2 номерын микрофоныг өгье. Нэмэлт хариулт Ням-Очир дарга Боловсролын ерөнхий газрын дарга.

Т.Ням-Очир: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир. Ер нь яах вэ технологийн шийдэл дээр бол бид нар 1, 2 дугаар ээлжид ашиглалтад орсон бүх объектуудын сургууль, цэцэрлэгээс хүмүүсийг авчирч, тусгайлан яг технологийн шийдэл гаргасан компаниудтай хамтарч хүмүүсээ бэлдсэн. Яг байнгын үйл ажиллагааг нь яаж хянах юм, эвдрэл гарвал ямар байдлаар мэдэгдэх юм, яаж яах юм гээд ингээд, тог тасарвал яах юм гээд ингээд бүх технологийн талаас нь бол бүх сургалт мэдээллүүдийг бол өгч байгаа.

Яг энэ зураг төсөв боловсруулсантай холбоотой, гүйцэтгэгч компаниудтай холбоотой бол одоо бид нар Өвөрхангай аймаг дээр бол Номуунзаяа гээд компани дээр бол гэрээ цуцлах мэдэгдэл өгөөд, энэ асуудлыг бол ингээд шийдээд явж байгаа. Бусад зураг төсвийн компаниуд, гүйцэтгэгч компаниудтай бол ажлаа шахаад, тодорхой үүрэг даалгавар өгөөд, ингээд ажиллаад явж байгаа. Тэгэхээр 1 дүгээр ээлж дээр бол Өвөрхангайн объектууд ер нь бол удааширч байгаа. Тэгээд энэ дээр бол гэрээ цуцлах мэдэгдлүүдээ өгөөд ингээд явж байгаа.

Сая сайд хэлсэн. Ашиглалтад орсон байгууламжуудын хувьд бол одоогоор ямар нэг байдлаар эвдрэл гэмтэл гараад, гүйцэтгэгч компани болон Боловсролын ерөнхий газар луу ийм асуудал үүсээд ашиглагдахгүй байна гэсэн ийм мэдээлэл юунууд бол ирээгүй. Ер нь бол яг ашиглалтад орсон объектууд дээр ЗГ-аас хэрэгжүүлж байгаа шүд угаах хөтөлбөр ч юм уу, тэгээд ашиглаж байж хэвшигье гээд ингээд байнгын ашиглалттай байх

чиглэлүүд дээр бас бид нар нөлөөллийн ажлууд хийж байгаа. Хамгийн гол зүйл бол ерөөсөө л ашиглалттай холбоотой асуудал байгаа. Удирдлагууд нь цоожлоод явчихдаг ч юм уу, тодорхой цаг заагаад нээдэг ч юм уу ийм асуудлууд үүсээд байгаа учраас ялангуяа алслагдсан сум орон нутгууд дээр бол байнгын ашиглалттай байлгах, тэнд шаардлагатай урсгал зардлуудыг бас шийдвэрлэх энэ чиглэлээр бол орон нутгийн удирдлагуудтай бол хамтраад ажиллаж байгаа гэдгийг онцолж хэлье.

Тэгээд түрүүн бас Ундрэм гишүүний юун дээр гарсан Сүхбаатар аймгийн, Сүхбаатар сумын 6 дугаар сургууль Сэлэнгэ аймгийн Ерөө сумын сургуулиудтай холбоотой. Бид нар бол ер нь жагсаалтыг гаргахдаа аймаг орон нутгаас эцсийн жагсаалтыг авч байгаа. Тэгэхээр түрүүн сайд онцолж хэлсэн тэй холбогдуулаад энэ жагсаалтууд гараад ирэх юм бол бид нар нягтлаад, тэгээд жишигээр 3 дугаар ээлж дээр бол объектуудын тоо нэмэгдсэн. 1 сум дээр байгаа цэцэрлэгээ орхичихдог ч юм уу, дотуур байраа орхиод, сургуулиа өгчихдөг. Тэгэхээр эдийн засгийн үр ашигтай байдлаа харах юм бол бид нар цогцоор нь хиймээр байдаг. Тийм учраас 3 дугаар ээлжийн объектууд нэмэгдээд, 4 дүгээр ээлж дээр ашиглалтад орсон газруудаа дахиж өгдөг ч юм уу, актлагдсан газруудаа дахиж өгч байгаа учраас 4 дүгээр ээлжийн жагсаалт жоохон хумигдах ийм хандлагатай байгаа. Тэгээд жагсаалтууд нэгж байгууллагаас гарч байгаа учраас сая Ундрэм гишүүнээс бас хүсэлтүүд ирсэн учраас бид нар сайдын өгсөн чиглэлийн дагуу нэмээд оруулаад явъя. Ерөө сумын хувьд бол 4 дүгээр ээлжид байгаа зураг төсөв гүйцэтгэж байгаа ийм байдалтай байна.

Б.Баярсайхан: Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Уг нь бол тэр хөрсний цэвдэг судлал энэ тэрийг бид нар

яг төсөл эхлэхдээ л Барилгын хөгжлийн төв дээр Баян-Өлгийд ямар байх вэ, Дундговь, Дорноговьд ямар байх вэ, газар орон нутаг хөрсөө сайн судалж байж технологио сонгоё гээд л уг нь ярьж, ярьж л явсан. Түүн дээр уг нь бид нар хугацаа алдахгүй байх боломж байсан уу гэвэл байсан. Сайдын хэлдгээр өнгөрсөн хойдох алдаагаа бид нар яриад яах вэ. Одоо алдаа гаргахгүйг л ярих ёстой байх.

Ашиглалт гэдгийг би болохоор байна шүү дээ тийм ээ нөгөө хэрвээ септик гэдэг юм уу, соруулах технологи байвал сургууль өөрөө соруулаад явах юм уу, тэрийг тийм ээ соруулдаг хүнийг нь сургууль нь өөрөө хариуцах юм уу, орон нутаг нь хариуцах юм уу гэж асуусан юм. Өөрөөр хэлэх юм бол соруулаад л явдаг байлаа гэхэд сургууль бидэнд тийм зардал байхгүй шүү дээ л гэдэг зүйл ярьж байсан. Бид нар газар орон нутагт нь очоод үзэхэд тийм ээ. Тэгэхээр тэрийг нь орон нутгийнх нь төсөвт нь тусгаж өгсөн үү л гэж асуугаад байгаа юм. Ашиглалт гэдэг юм би тэрүүгээр нь асуусан шүү. Нөгөө талаар хариуцлага гэдэг зүйлд нь байна шүү дээ тийм ээ, одоо тэр 800 метрийн хэмжээнд газар шугам хоолойгоо дутуу зураг хийж төсөв авчхаад, дахиад ажил хийхээр ажил хойшлоод байгаад байгаа тэр нөхдүүдийг яах юм бэ.../минут дуусав/

Б.Баярсайхан: Жаргалмаа гишүүн маш чухал асуудал ажлын хэсгийн гишүүний хувьд, орон нутагт ажиллаж байгаа, шалгалт хяналтаа тавьж байгаа гишүүний хувьд бол маш чухал асуудал асуулаа. Зарим сэтгэлтэй сумын Засаг дарга нар бол нэг сантехникийнхээ слесарийг сумдаа бүтэн хариуцах, энэ дотроо энэ шинээр байгуулагдаж байгаа ариун цэврийн байгууламжийг нэмж хариуцаад явах, зарим санаачилгатай сургуулийн захирлууд эцэг эхчүүдийнхээ хүчийг ашиглаад ингээд бас энэ хийсэн бүтээн байгуулалтаа тордоод явах ийм байгаа. Гэтэл ихэнх сумд дээр дахиад нэг орон тоо нэмж өгөхгүй бол бид нар энэ ариун

цэврийн байгууламжаа арчилж тордож чадахгүй байна, засвар үйлчилгээг нь хариуцаж чадахгүй байна гэсэн асуудал гарч байгаа. Энийг дэд ажлын хэсгийн дарга юу гэж үзэж байна, ямар шийдэл байна вэ? 2 номерын микрофон.

Т.Ням-Очир: Яг энэ асуудал дээр аймгийн Засаг дарга нар, орон нутгийн удирдлагуудтай бол нягт хамтарч ажиллаж байгаа. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжоор бол урсгал зардал бол орон нутаг хариуцаж байгаа. Тэгэхээр яг ашиглалтад орж байгаа энэ ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, сургуулиуд дээр улсын комисс байнгын ашиглалтад ажиллах улсын комисс ажиллаад сургууль, цэцэрлэгт нь хүлээлгэж өгөөд, энэ дээр соруулах нь бол соруулдаг, зөврийн устай бол зөврийн устай гэдэг энэ зардлуудыг нь бид нар урсгал зардал дээр нь суулгаж өгөхөөр аймгийн удирдлагуудад бол сайд 2 удаагийн чиглэл, бид нар бол орон нутгийн удирдлагуудтай бас нэг удаагийн хурал хийж ийм чиглэл өгсөн. Тэгээд сая өчигдөр бол Монгол Улсын ЗГХЭГ-аас орон нутгийн удирдлагуудтай яамнууд бол хурал хийсэн. Энэ дээр бас сайд онцгойлж хэлээд, 300 гаруй объект ашиглалтад орсон шүү. Ашиглалттай холбоотой зардал суух ёстой шүү, хүний нөөцийг бол бид нар мэргэжлийн компаниудтайгаа хамтраад бэлтгээд явчихна гэдэг чиглэлээр бас ингээд чиглүүлэг өгөөд ингээд хамтраад ажиллаж байгаа. Ер нь бол технологийн шийдэл дээр бол 1, 2 дугаар ээлж дээр шугамын асуудал энэ тэр яригдсан болохоос биш 3, 4 дүгээр ээлж дээр бол ийм асуудал одоогоор бол гараагүй байгаа. Ийм байгаа.

Б.Баярсайхан: Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ сургуулиуд дээр баригдах энэ ариун цэврийн байгууламжийн асуудал маш

чухал асуудал юм. Энэ манай эмэгтэй гишүүд санаачлаад оруулж ирсэн бас баяр хүргэе. Энэ яг хөдөө орон нутгаар яваад үзэхэд тэр 1 дүгээр ангиас тэгээд эхлээд сурч байгаа ялангуяа эмэгтэй хүүхдүүдийн хувьд тийм ээ тэр бие засах руу нь орохын арга байхгүй, та нар манай яамныхан очиж үзсэн л байх л даа. Бас шийдэх л ёстой асуудлууд байсан. Тэгээд одоо ингээд тойрог дээр яваад харж байхад яг нэг гүйцэтгэлүүд нь нэг тийм олигтой явахгүй байгаа юм шиг харагдаад байгаа юм. Манай Барилгын хөгжлийн төвийнхөн маань яг энэ тэр цэвэрлэх байгууламжийн сая Жаргалмаа гишүүн бас асуугаад байна. Чухал асуулт шүү дээ. Энэ дараа нь урсгал зардлыг нь яг хэн нь хариуцаад явах нь тодорхой биш тийм ээ. Аймаг орон нутаг нь зарим сумууд чинь тэрийгээ хариуцдаггүй. Ингээд энэ чинь өч төчнөөн мөнгө төгрөг зарцуулаад барьчихсан зүйлийг дараа нь хаалгыг нь түгжчихсэн, хажуудаа байгаа нөгөө нэг энгийн бие засах газартаа ороод л ороод, гараад гүйгээд байдаг хүүхдүүд тийм ээ. Энэ тэр дээр яамныхан бас бодлогын юугаар аягүй сайн анзаарах нь зөв байх.

Тэгээд энэ Барилгын хөгжлийн төвийнхөн сууж байна. Яг одоо тэр инженерчлэлийн хувьд ер нь чанар чансаа нь ер нь яг хэр юм баригдаад байгаа юм бол? Миний ойлголтоор болбол зарим сумууд дээр яг тусад нь объект бариад, зарим сургуулиуд дээр нь байгаа объектыг нь ашиглаад тэрэн дотор нь суурилуулаад явж байгаа гэж би ойлгож байгаа. Барилгын хөгжлийн төвийнхөн маань яг хяналтаа хийж амжиж байгаа юу, энэ чинь бараг бүх сумуудаар баригдаж байгаа шүү дээ энэ зүйл маань. Яг энэ гүйцэтгэл дээр нь хяналт тавьж ажиллаж чадаж байгаа юу? Барилгын хөгжлийн төвийнхнөөс бас асуугаадахъя. Чанар чансааг нь.

Тэгээд яах вэ энэ асуудалтай нэг их бас айхтар холбоотой биш, манай яамныхан сууж байгаа учраас манай аймаг чинь энэ боловсролын салбар нь

нэлээн дуулиантай л байдаг л аймаг л даа. Жишээлбэл яг өнөөдрийн байдлаар Баян-Өлгий аймгийн төв талбай дээр нэг багш суулт зарлачихсан, сургуулийн захирлыг нь хууль бусаар томилчихсон гэх юм. Энэ гишүүдэд бид нарт хандаад байгаа юм. Тэр тойргийнхоо сонгогдсон гишүүдэд энэ сургуулийн захирлаа ингээд хууль бусаар томилчихлоо. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн маань шууд тэр захиргааны байгууллагынхан яг зөв томилсон юм уу, буруу томилсон юм уу гэдэгт нь оролцох, оролцоод судлаад гүйгээд байх боломж байхгүй. Энэ нь эргээд нөгөө улс төрийн шинжтэй нэг асуудал болчихсон. Энэ дээр яг салбарын яамныхан маань энэ захирлыг томилсон нь зөв байжээ, хуулийн дагуу томилжээ, үгүй болбол хууль бусаар томилчихсон юм байна гэдгийг нь хагалаад нэг талд нь гаргачхаж болдоггүй юм уу? Энэ чинь улс даяар л шуугиулаад л энэ өвлийн хүйтэнд тэр нэг эмэгтэй ингээд суулт зарлачихсан. Энэ дээр Ням-Очир дарга танайх яг шууд хариуцдаг л танай салбарын асуудал шүү дээ. Тийм учраас энэ дээр энэ асуудлыг нэг 2-т нь хариулаад өгчхөөч тэгэх үү Ням-Очир дарга.

2 дугаарт Барилгын хөгжлийн төвийнхөн маань яг инженерчлэлийн хувьд яг очиж хяналтаа тавьж та нар амжиж байгаа юу? 300 гаруй сум дээр та нар хяналт тавьж байгаа гэхэд би бол итгэхгүй байна. Ингээд 2 асуулт байна. Нэгдүгээрх нь Барилгын хөгжлийн төвөөс, 2 дугаарт Ням-Очир дарга манай аймаг дээр болоод байгаа асуудлыг та харж байгаа байх. Энэ дээр нэг яаж шийдэх ёстой юм. Яг өнөөдрийн байдалд төв талбай дээр нэг багш маань суулт зарлачихсан байж байгаа. Ийм 2 асуулт.

Б.Баярсайхан: Хэн хариулах вэ? Барилгын хөгжлийн төв энэ ариун цэврийн байгууламж яг энэ 819 объект чанартай болох уу, чанартай гүйцэтгэгдэж байгаа юу, чанарын хувьд бид нар санаа зовох зүйлгүй байж болох

уу гэдэг энэ хамгийн чухал асуудлыг асууж байна. Тэгээд Алтангэрэл хөгжлийн төвийн Барилгын хөгжлийн төвийн ерөнхий инженер ерөнхий инженер Алтангэрэл 2, 3 номерын микрофон өгье.

Д.Алтангэрэл: Сайн байцаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Барилгын хөгжлийн төв ерөнхийдөө хяналт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга байгууламж тэр тусмаа энэ ариун цэврийн барилга байгууламж дээр болбол маш анхаарал тавьж ажиллаж байгаа. Бид бүхэн 3 бүс болгоод зүүн, баруун, төв гээд 3 бүсээр манай нийт 35 захиалагчийн хяналтын инженер болбол тухайн үедээ комиссоор ажилласан үедээ, томилолтоор ажиллаж байгаа үедээ болбол байнга хүрч ажиллаж байгаа. Байнгын өдөр тутмын хяналтыг бас аймгийнхаа Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженер техникийн ажилчид бас тавьж байна. Ер нь болбол ажил болгон бол чанартай бас болж байна гэж бас хэлж чадахгүй. Яагаад гэхээр тэнд сонгон шалгаруулалтаар орж ирсэн компанийн чадавхын асуудлууд байна. Түүрүүн Ням-Очир дарга хэллээ. Нөгөө Өвөрхангай ажил болбол гүйцэгдэхгүй 1 дүгээр ээлжийн ажил бас маань ингээд зогсчихсон ийм байдалтай, гэрээ цуцлагдаж байна. Тэгэхээр тухайн хамаарч байгаа ААН-ээс хамааралтай бас юмнууд байна.

Ер нь инженер, техникийн ажилчид маань чанарын түвшинд чанартай гүйцэтгэл хийхийн тулд газар дээр нь гарч байгаа асуудлуудыг газар дээр нь шийдвэрлээд явж байна. Зарим барилга байгууламжууд яг ингээд угсралтынхаа шатан дээр яваад очихоор объект нь өөрчлөгддөг. Нөгөө төлөвлөсөн газар нь цэвдэгтэй гарч ирдэг. Тийм учраас бид нар нөгөө зөөж өөр объект, өөр газарт байршуулах гэх мэт бол саадууд болбол гарч байдаг. Тэгэхээр аль болох л чанартай, хяналтыг

бол сайн тавьж, ашиглалтад оруулах талд бид нар анхаарч ажиллаж байна. Баярлалаа.

Б.Баярсайхан: 2 номерын микрофонд Ням-Очир дарга нэмж хариульга.

Т.Ням-Очир: Тийм. Баян-Өлгий аймгийн Раиш... багшийн асуудал байгаа. Бид нар энэ талаар бол мэдээлэлтэй байгаа. Боловсрол, шинжлэх ухааны сайд, БШУЯ-ны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газраас энэ асуудалтай холбоотой багшид нөхцөл байдал, хууль, эрх зүйн асуудлыг тайлбарласан. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт энэ асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой 2-оос 3 удаагийн албан бичиг хүргүүлсэн байдаг. Багш бол энэ асуудлыг хүлээж авахгүй, энэ захирал энэ албан тушаалд байх ёсгүй гэдэг хувийн шийдвэрээ гаргаж суулт зарлахаа бол албан ёсоор зарласан байгаа. Энэ суулт зарлахтай холбоотойгоор бид нар бол аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газартай бол холбогдсон, багшийг эрсдэлд оруулж болохгүй, хүлээж авч уулзах ёстой, сургуулийн удирдлагуудтай холбогдож ажиллах ёстой. Тэгээд холбогдох мэдээ мэдээллийг бидэнд ирүүлж, шаардлагатай арга хэмжээ авсан эсэх талаараа хариу өгөх ийм чиглэлийг бол хүргүүлчихсэн байгаа. Одоо бол мэдээж сайдаас болон холбогдох яамны газраас Боловсрол, шинжлэх ухааны газар аймгийн удирдлагуудад бол бичиг хүргүүлчихсэн байгаа учраас аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар холбогдох арга хэмжээг авч бид нарт мэдэгдэх ёстой ийм байдалтай байж байгаа.

Б.Баярсайхан: Алтанхуяг инженер ийм аль болохоор, зарим газар чанаргүй гүйцэтгэж байгаа гэсэн ийм яриа бол таны амнаас хэзээ ч гарч болохгүй. Би энэ ажлын хэсгийн ахлагчийн хувьд, энэ төслийг санаачлагчийн хувьд бас танд бүүр

хариуцлагатайгаар хэлье. Бидний гол ярьж байгаа юм энэ төсөв мөнгө нь ийм хүрэлцээтэй байхад, тэгээд энэ хүний эрхийн асуудал, хүүхдийн эрхийн асуудал, хөгжлийн асуудал ярьж байхад аль болохоор гэдэг юм ярьж болохгүй. Энэ Амарсанаа даргад нь энд байгаа хүмүүс нь дамжуулж хэлээрэй. Хурал цуглаандаа ирж оролцож байгаарай. Ийм чухал асуудал дээр орондоо хүн томилж дахиж явуулах тийм асуудал байхгүй шүү. Тэгээд аль болох гэж та нар байж болохгүй. Барилгын хөгжлийн төв бол маш эрх мэдэлтэй ажилладаг ийм байгууллага. Инженер, хяналтын инженерүүд нь өндөр цалинтай, орон нутагт ажилладаг. Хэрвээ энийг чанаргүй болгосон байх юм бол та нарын л буруу. Тэгээд өнөөдөр бас протоколд энэ хурал тэмдэглэгдээд явж байгаа учраас энэ нэг бүтээн байгуулалт чанаргүй байх юм болбол энэ ажил хариуцаж байгаа дэд ажлын хэсэгт орж ажилласан бүх хүнтэй хариуцлага тооцох болно шүү. Дараа дараагийн ЗГ, Их хурал гэдэг зүйлийг бас би хэлчихье. Битгий дахиж амнаасаа ийм юм гаргахгүй. Хэрвээ та ингээд яриад сууж байгаа бол ажил чинь бас ямар түвшинд явагдаж байгаа нь нүдэнд харагдаж байна. Төсөөлөгдөж байна. Энх-Амгалан сайд асуулт асуух уу? Дамдинням гишүүн асуулт асууя. Чинзориг гишүүнийг нэмээрэй.

Г.Дамдинням: Манай гишүүд Байнгын хорооны хурал дээр тэгээд л энэ янз янзын л асуудлууд ярьж байна. Энэ манай боловсролын салбарт байгаа ажиллаж байгаа энэ хүмүүсийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой л асуудлууд явж байгаа шүү дээ. Ажил удааширч байгаа, хүмүүсийг хууль бусаар дарамталж байгаа, шантаажилж байгаа энэ асуудлуудыг цэгцлэгдэхгүй болбол энэ ямар ч ажил дандаа хойшоо болно, ямар ч үр дүнгүй болно. Дээгүүрээ бид нар мянган сайхан хууль, мянган сайхан журам гаргаад хэрэгжихгүй. Өнөөдрийн тэр Баян-Өлгий аймагт гудамжинд энэ хүйтэнд гараад

зогсчихсон байгаа багшийн асуудал болбол бас л тэгээд л хууль бус дарамт шахалттай холбоотой л асуудал шүү дээ хөөрхий. Нийтийн анхааралд орж ирж байгаа нь л энэ болохоос зөндөө л асуудал байна. Энэ салбарын хуулиуд хагас жил гаруйн өмнө батлагдаад, ингээд хэрэгжээд явж байна. Тэгээд энийг дагаад гарах төрөл бүрийн журмууд гарах ёстой. Үгүй ээ би зүгээр ганцхан захын жишээ л хэлье.

Намайг дарга болгохгүй болбол чамайг Улсын Их Хурлын гишүүнээс чинь унагаана даа гэж дарамталж байгаа гишүүд рүү, Улсын Их Хурлын гишүүд рүү ингээж мессеж бичиж шууд хэлдэг ийм хүмүүсийг л, эсвэл удирдлагад нь ажиллаж байгаа багш нар хөөрхий нөгөө муу ажлаа хийгээд өдөр, шөнөгүй гүйж байгаа төрийн албан хаагчдыг хууль бусаар дарамталдаг, ааш авираа гаргадаг ийм хүмүүсийг л асуудлыг нь шалгаад та нар нэг шийдээч гэдэг бичиг явуулахаар манай яамны Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлагдаагүй байгаа учраас энэ хүмүүст хариуцлага тооцох боломжгүй байна гэсэн бичиг манай сайдаас ирэх юм. Улс даяараа л төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, төрийн албаны үр дүнг сайжруулах, харилцааг сайжруулах, ард иргэдэд үйлчлэх үйлчилгээг нь сайжруулах, боловсролын чанарыг сайжруулах гээд л бид нар ярьж байгаа. Энэ ёс зүйгүй хүмүүсээ яах юм та нар, ингээд дүрэм журам чинь батлагдаагүй байна, тийм учраас бид нар хариуцлага тооцож чадахгүй гээд толгойг нь илээд сууж байх юм уу?

Манай яамны ажил зарим хэсэгтээ сайн байгаа. Нэг их бүгдийг нь муулаад байх юм алга. Тэгэхдээ сүүлдээ будаач, будаач гэхээр сахлаа будав гэдэг рүү ороод үзэмжээрээ асуудлыг шийдээд байгаа байдал руу ороод байгаа юм биш биз дээ гэсэн ийм бодол руу орж байгаа шүү. Хатуудаа хатуу, зөөлөндөө зөөлөн, Их Хурал гишүүний хувьд энд бас төрийн ажлыг явуулчих юм сан, ард иргэдэд бас

нэг шахалт дарамтгүй, алаг үзэлгүй шиг энэ төрийн албыг үйлчилгээг хүргэчих юм сан, хүргүүлчих юм сан гээд л ингээд л ажиллах юм. Хувийн асуудал мэтээр л ярих юм. Зөндөө гомдол ирж байна шүү дээ. Зөндөө гомдол ирж байна.

Өнгөрсөн 7 сард хууль батлагдчихад, 12 сард Ёс зүйн дүрэм батлагдаагүй, Сахилга хариуцлагын дүрэм батлагдаагүй байна гээд хүнд хариуцлага тооцож чадахгүй байна гэдэг бол шившиг шүү дээ. Хэзээ батлагдах юм, хэзээ арга хэмжээ авах юм бэ? Ийм хүмүүсийг энэ салбарт ажиллуулаад байж болох юм уу? Энэ Монголын мянга мянган хүүхдүүдийн ирээдүйд ийм хүмүүсээр удирдуулаад байж болох юм уу яамныхан. Ингээд өөр ажлууд хийнэ гээд бид нар бас зүтгээд байдаг. Энийгээ яах юм бэ?

Б.Баярсайхан: Салбарын сайд Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Дамдинням гишүүнээ болж байгаа ч юм байгаа, болохгүй ч юм байгаа энд уурлаж бухимдаад яах вэ та. Би бас Улсын Их Хуралд 3 удаа сонгогдож байгаа гишүүн, Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол дарга хийх ажил биш шүү дээ. Бүгдийг загнаж, тийм бүгдийг би мэднэ, бүгдийг би томилно, бүгдтэй нь би хариуцлага тооцно. Миний үгэнд орсон улсууд нь ёс зүйтэй, миний үгэнд ороогүй улсууд нь ёс зүйгүй гэдэг ийм авир Улсын Их Хурлын гишүүнээс гарч хэрхэвч болохгүй, хэрхэвч болохгүй. Би энийг залуу гишүүний хувьд өөрт чинь захъя, яривал олон л юм ярьж болно. Энэ микрофон дээр.

Надад бас үг хэлэх бүрэн эрх байгаа Улсын Их Хурлын гишүүний хувьд. Тэгээд нэг тойргийн нэг ганц нэг асуудлаас болсон үл ойлголцоос болж бүхэл бүтэн салбарыг харлуулах гэж байгаа бол энийг би хүлээн зөвшөөрөхгүй шүү. Өнөөдөр ёс зүйтэй олон зуун мянган багш нар байгаа. Та бүх багш нарыг, боловсролын салбарынхныг та бүгдийг

нь ёс зүйгүй болчихлоо гэж дайрч байгаа бол харин би өмөөрнө шүү эд нарыгаа. Хэний ч өмнө өмөөрнө, яамныхныгаа ч өмөөрнө би. Тэгээд ингээд Ёс зүйн журам батлагдаагүй гэж та юу яриад байгаа юм бэ? Ёс зүйн, Ёс зүйн журамгүй ер нь яам, Ёс зүйн журамгүй байгууллага гэж ер нь хаана байдаг юм бэ? Бид нар 22, 23 оныг Ёс зүйн жил болгож салбарынхаа хэмжээнд зарласан. Нөгөө нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг ийм л асуудлууд байгааг би үгүйсгэхгүй.

Гэлээ гэхдээ нэг ийм зүйлийг өөрийнхөө үл ойлголцлоос болсон зүйлийг ингээд дөвийлгөж, бүхэл бүтэн салбарын хийсэн ажил, бүхэл бүтэн энэ салбарт зүтгэж байгаа нойр хоолгүй зүтгэж байгаа энэ хүмүүсийн ажлыг үнэгүйдүүлэх гэж байгаа болбол энэ болбол тийм явууртай асуудал бол биш шүү. Би дахиад хэлье. Улсын Их Хурлын гишүүн гэдэг дарга хүн биш шүү. Энэ бол ард түмний төлөөлөгч, ард түмний зарц, ард түмний төлөөлөл байх ёстой. Тэр тойргийг ард түмэн чинь тойргийг төлөөл гэж бид нарыг сонгосон болохоос биш, энэ тойргийн дарга болоорой, энэ тойргийн эзэн болоорой гэж бид нар сонгоогүй шүү. Энэ үгийг би харин хатуухан хэлчихье.

Б.Баярсайхан: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Яах вэ бас олон жил парламентад суугаад, хүний үгийг өөр тийш нь хувиргаж, эргүүлэх чадвар байгаа л байх. Ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой асуудлууд байна. Би Монголын мянга мянган багш нарын сайн сайхны төлөө, боловсролын салбарыг сайжруулахын төлөө хуулийг нь хэлэлцээд, тантай хамт зүтгээд явж байгаа. Хууль сайн болсон. Багш нар зүтгэж байгаа. Багш нарынхаа төлөө дуугарна, ажилчдынхаа төлөө дуугарна. Таны 2023 оны 12 сарын 5-ны 1А58 55 дугаар ийм бичиг дээр манай төрийн албаны дэд хорооны ёс зүйн дүрэм

батлагдаагүй учраас бид нар энэ ёс зүйгүй хүмүүстээ хариуцлага тооцож чадахгүй байна гэдэг ийм бичиг надад өгчихсөн байна л даа. Тэгээд энэ журмаа баталчихсан уу, үгүй юү? Хэзээ батлаад хариуцлага тооцох юм, хариу өгөх юм бэ? Энэ бичиг дээр байна.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье. Хариулт.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ үгүй хэрэлдээгүй, хэрэлдээгүй. Одоо яагаад байх юу байх вэ. Үл ойлголцлууд байлгүй яах вэ, үл ойлголцлууд үргэлж байдаг. Гэхдээ тэрийг болбол заавал ч үгүй ингэж нэг тийм урдах микрофоноо ашиглаж, эрх мэдлээ ашиглаж, эсхүл Их Хурлын тогтоол батлуулах хэлбэрээр ийм маягаар явж болохгүй л дээ, ажил ингэж явж болохгүй. Ер нь Ёс зүйн зөвлөл чинь хуралдаад ёс зүй алдсан гишүүдтэйгээ, албан хаагч нартайгаа хариуцлага тооцоод явдаг энэ чинь тогтолцоо шүү дээ. Тийм тогтолцоо шүү дээ. Тэгээд ямар нэгэн тийм сургууль бүр дээр бид нар Эцэг, эхчүүдийн зөвлөл, Ёс зүйн зөвлөл гэдэг юунууд чинь байгуулагдаад л ингээд л явж байгаа. Тэрнээс биш одоо ингээд юу гэдэг юм журам гараагүй байна тийм учраас ёс зүйгүй хүмүүсээ бид нар ингэж хэлэлцэх ийм үндэслэл үүсээгүй байна, эрх зүйн орчин үүсээгүй байна гэдэг нэг ийм юм хэзээ ч, аль ч байгууллага дээр байхгүй л болов уу гэж би бодох юм. Энэ жаахан буруу ойлголт, буруу ойлгосон явдал юм болов уу л гэж би ойлгоод шүү дээ.

Б.Баярсайхан: Дэгээрээ дахиад нэг боломж тодруулга хийх, Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангаас 2023 оны 12 сарын 5-нд 1А 58 55 тоот албан тоот надад хариу ирсэн. Би энийг бас бичиг, ажил хэргийн шугамаар шийдэх гэж үзсэн. Тэгээд энэ дээр нэг ийм хэсгийг нь би уншаад өгчихье. Төрийн албан хаагчийн ёс зүйн

тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Ёс зүйн хорооноос төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг батлахаар заасан бөгөөд энэхүү журам одоогоор батлагдаагүй байгаа тул аливаа ёс зүйтэй холбогдох үйл ажиллагааг шийдвэрлэх эрх зүйн нөхцөл хараахан бүрдээгүй болно. Үгүй ээ одоо энийг юу гэж ойлгох вэ? Өөрөөр хэлбэл журам байхгүй учраас бид нар хариуцлага тооцож чадахгүй байна л гэсэн хариу байгаа байхгүй юу. Энэ дээр л хариулт нэхээд байгаа юм би. Энд ерөөсөө миний хувийн асуудал алга. Багш нарыгаа боловсролын салбар дээрээ ёс зүй, сахилга хариуцлагыг мөрдүүлье л гэж байгаа юм. Өөр юм байхгүй. Сайн ажлаа хийж байгаа хүмүүс байгаа, саараар ашиглаж байгаа хүмүүс ч байгаа.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд хариулъя. Тэгээд дараа нь Чинзориг гишүүний асуултыг өгье.

Л.Энх-Амгалан: Нэг үг, өгүүлбэр мушгиад байх шаардлага байхгүй дээ Дамдинямаа, жаахан хүлээцтэй байж сур миний дүү. Тэгээд юу энэ угаасаа сая чинь Улсын Их Хурлаас чинь Төрийн ёс зүйн тухай маш том хууль батлагдаж гарчихсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гээд маш том хууль батлагдаад гарчихсан байгаа шүү дээ. Тэгээд ЗГ хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгээд би түрүүн хэлсэн. Ер нь Монгол Улсын ЗГ дээр ингээд олон журам гардаг. Нэг хууль батлагдсанаар олон журам гардаг, журмаар зохицуулна, журмаар зохицуулна гэдэг явдал ингээд хуулиасаа илүү журамтай болж байдаг нэг ийм нөхцөл байдал бид нар үүсчихсэн байна. Бараг юу гэлээ энэ чинь. Би буруу сонсоогүй бол Чинзориг сайдаа 400 гаруй журам гэсэн билүү тийм ээ, хуулиасаа илүү, биш ээ 1200 орчим, 400 гаруй хуультай мөртөө 1200 орчим журмууд гарчихсан байна. Энэ 1200 орчим журмууд чинь хуулиасаа давчихсан, хуулийнхаа зөрчилтэй журмууд байна. Нэгэнт Улсын Их Хурлаар баталчихсан

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гэдэг ийм том Үндсэн хууль шиг хуультай, ёс зүйн Үндсэн хууль шиг хуультай болчихоод байхад.../минут дуусав/

Б.Баярсайхан: Чинзориг гишүүнд микрофон өгье. Асуулт асууя.

С.Чинзориг: Энэ ариун цэврийн байгууламж барих асуудлыг л 3 жилийн өмнө эхэлсэн байх. Тэгээд л яриад л байгаа юм. Бусад аймгуудыг нь мэдэхгүй. Зүгээр манай Өвөрхангай аймаг дээр л энэ жаахан хэрэгжилт их муутай, явц их муутай байгаа юм. Яагаад ингээд байдаг юм. Манай аймаг чинь 19 сумтай, тэгээд энэ хэрэгжилт их муутай байгаа юм. Би бас ноднингийн Байнгын хороон дээр яриад л байсан юм, бас хуваарилалт нь хүртэл шог байна гээд л, жорлонг хүртэл дээгүүрээ хуваагаад авчих юм уу гээд л дэмийрээд л байсан юм. 1 дүгээр ээлжид нь манай Өвөрхангай аймгаас тавхан сум орсон байдаг юм 1, 2 дугаар ээлжид тавхан сум орсон байдаг. Тэгээд цаад үлдэж байгаа 14 сум нь, 13 сум нь 3, 4 дүгээр ээлжид орсон. Тэгээд тэр 3, 4 дүгээр ээлж нь болбол эхэлж байгаа ч юм байхгүй. 1, 2 дугаар ээлжид орсон 5 сум нь одоогоор бараг ашиглалтад орсон юм байхгүй л байгаа юм даа. Ноднин л магад нэг жоохон байшингийнхаа хажууд нүх ухчихсан байсан. Яаж байгаа вэ гэхээр нөгөө цэвэрлэх байгууламж хийх гэж байгаа юм гээд л байгаа юм. Тэгээд Өвөрхангай аймаг дээр энэ хэрэгжилт их муутай байгаа юм.

2 дугаарт 1, 2 дугаар ээлжид орсон сумдын тоо нь цөөхөн, 1 дүгээр ээлжид нь 2-хон сум, 2 дугаар ээлжид нь 3-хан сум, тэгээд бусдыг нь бүгдийг нь ингээд 3, 4 дүгээр ээлж ингээд тавьчихсан, ингээд хуваарилалт нь хүртэл шог байна, жорлон ч байсан дээгүүрээ хуваагаад авчих юм уу гээд л би бас ноднин дэмийрээд л байсан. Нэг их худлаа ч үг биш, үнэний л ортой л доо. Тэгээд одоо Ням-Очир даргаа Өвөрхангай аймагт яг одоо бодитойгоор

хэрэгжээд ашиглалтад орчихсон, хүлээгээд авчихсан хэдэн сум байгаа юм бэ? Хэдэн сумын, хэдэн хэдэн байгууламж байгаа юм бэ? Тэр 1, 2 дугаар ээлжид орсон тэр 5 сум чинь одоогоороо дууссан уу, үгүй юү, яг албан ёсоор хүлээгээд авчихсан юм байна уу, үгүй юү? Энэ их явц удаантай байгаа. Миний мэдэхэд 3 дахь жил дээр энэ 5-хан сумыг л яриад байгаа юм. Одоо тэгээд үлдэж байгаа 3, 4 дүгээр ээлжид орсон сумууд нь хэзээ эхлэх юм бэ? Одоо ингээд сонгуулийн жил. Хавар бид нар тэгээд энэ хэр үр дүнтэй болсон, хэрэгжилт юутай болсон гэж очих юм бэ? Үгүй бол Өвөрхангайн гишүүд хөөцөлдлөгөө муутай, санаа, санаачилга муутай байсан учраас хэрэгжээгүй гээд бид нар хэлэх юм уу. Аягүй бол та нарыг бол тэгж хэлэх л байх л даа. Тэгэхээр одоо энэ 5 эхний ээлжид 1, 2 дугаар ээлжид орсон 5 сумын чинь ядаж яг хэд нь ашиглалтад орчихсон юм, хүлээгээд авсан юм хэд байгаа юм бэ энэ 5-хан сумаас чинь. Тэгээд 3, 4 дүгээр ээлжид орсон тэр бусад 13 сум чинь хэзээ эхлэх юм, хэзээ дуусах юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариу хэлээч.

Би болбол ноднин яриад байсан. Ер нь болбол энийг чинь тэгээд орон нутаг нь хариуцна, орон нутаг нь тендер зарлана гээд байсан тэр лүүгээ орсон билүү гэвэл яаж байгаа билээ. Уг нь орон нутгийнхан болбол орон нутаг өөрсдөө тендер зарлаад, гүйцэтгээд сонгоод явбал уг нь хяналттай, оролцоотой, дэмжлэгтэй бас болмоор байна л гээд л байдаг юм. Тэгээд яах юм бэ? Тэгээд яг ер нь тэгээд яагаад энэ хэрэгжилт удаантай, удаан байгаа юм бэ? Манай энэ эхний 1, 2 дугаар ээлжид, 1 дүгээр ээлжид 2 сум нь орсон гээд л байдаг юм. 2 дугаар ээлжид 3 сум нь орсон л гээд л байдаг юм. Ноднин очиход бол нөгөө бүгдээрээ байшингийнхаа буланд нь нүх ухчихсан, хоосон л байсан. Одоо тэгээд ашиглалтад орсон уу, дууссан уу, дуусаагүй юу, хэзээ хүлээж авсан уу, үгүй юү? 3, 4 дүгээр ээлжид орсон тэр 13 сумыг чинь тэр олон байгууламжууд

тэгээд хэзээ дуусах юм бэ, энэ онд дуусах юм уу, дуусахгүй юм уу, дуусахгүй юм уу? Ингээд сонгуулиар бид нар хэлэх уг байхгүй байна. Дээгүүрээ болбол сайхан яриад л байдаг, яриад л байдаг, тэгээд ингээд үр дүн муутай байх юм, энэ юутай холбоотой юм бэ?

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн дарга Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир 2 дугаар микрофон дээр хариулъя.

Т.Ням-Очир: Чинзориг сайдын асуултад хариулъя. Өвөрхангай аймаг ерөнхийдөө 4 ээлжийн 19 сумын 64 объект жагсаалтаар батлагдсан байгаа. Сая гишүүн хэллээ 1 дүгээр ээлжид 2 сумын 7 объект, 2 дугаар, 2 дугаар ээлжид 3 сумын 13 объект орсон байгаа юм. Тэгээд яах вэ 1, 2 дугаар ээлж дээр түрүүн бас Жаргалмаа гишүүн асуусан. Яг 1, 2 дугаар ээлж дээр нэлээн удааширалтай явагдсан аймаг бол Өвөрхангай аймаг. Ялангуяа 1 дүгээр ээлжийн 2 сумын Есөнзүйл, Бүрд сумын тендер дээр Номуунзаяа гэдэг компани шалгарсан. Ажил гүйцэтгэл удааширч, ажлаа хийхгүй байсан учраас бид нар 1 дүгээр ээлжээс цуцлаад, 4 дүгээр ээлж дээр зураг төсвийг зарласан. Ингээд 4 дүгээр ээлжид оруулаад явж байгаа. 2 дугаар ээлжийн 13 сумын объектыг бид юу, 3 сумын 13 объектыг бид нар ашиглалтад хүлээгээд авчихсан. Харин яг хэлэхэд 3, 4 дүгээр ээлж дээр хамгийн ажил сайн явж байгаа Өвөрхангай аймаг байгаа. 15 сумын 44 объект жишээлбэл 3 дугаар ээлжийн зураг төсвийн арван, 6 сумын, 6 сумын 18 объектын зураг төсвийн ажил бүрэн магадлагдаж дуусаад, 17 объект дээр нь барилга угсралтын ажил үргэлжлээд, 1 объект түрүүлээд хүлээгээд авчихсан байж байгаа. Архангай, Өвөрхангай 2 дээр л 3 дугаар ээлжийн объектууд түрүүлж хүлээж авч байгаа. Энэ дотор Өвөрхангай аймгийн 1 объект хүлээгдээд авчихсан байж байгаа.

4 дүгээр ээлж дээр хамгийн түрүүнд зураг төсвийн магадлал хийгдэж дуусаад, тендер зарлагдчихсан нь Өвөрхангай аймаг байж байгаа. Тэгэхээр 3, 4 дүгээр ээлж дээр бол бид нар 24 оны эхний хагас жил дээр бол Өвөрхангай аймгийн энэ ариун цэврийн байгууламжийн гүйцэтгэл бол эхний хагас жил дээр нэлээн сайн гарна гэсэн ийм хүлээлттэй байгаа. Харин 1 дүгээр ээлжийн тэр Номуунзаяа компани дээр бид нар бол гэрээгээ цуцлаад, 4 дүгээр ээлж дээр зураг төслийг зарлаад, тэгээд ажлыг шахаж ажиллана гэсэн ийм байдалтай байж байгаа. Ер нь яах вэ сайд асуугаад байна. Яагаад 1, 2 дугаар ээлж дээр манай аймгаас цөөхөн сум оров гээд. Ер нь бол жагсаалтыг саналыг аймгаас авч байгаа. Тэгээд аймгаас ирсэн саналуудыг нь эрэмбэлж жагсаагаад, ажлын даалгаврынх нь дагуу жагсаагаад ингээд яаж байгаа. Тэгэхээр бол аймгаас бол ийм саналууд ирсэн. Энэний дагуу жагсаалт батлагдсан гэж ойлгож болох байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Баярсайхан: Чинзориг сайд тодруулж асууя.

С.Чинзориг: Одоо тэгээд тэр 1 ээлжийн 2 сумын чинь объект хэзээ дуусах юм бэ? 2 дугаар ээлжийн 3 сумынх болбол дуусчихсан юм байна гэж ойлгож байна тийм үү? Тэгээд хамгийн 3 жилийн өмнө эхэлсэн шүү дээ, наад 2, 1 дүгээр ээлж чинь. 3 жилийн өмнө эхэлсэн юм одоогоороо дуусаагүй л байгаа байхгүй юу.

2 дахь асуудал нь Байнгын хорооны даргаа энийг та нар цаашидаа бас анхаарна биз ажлын хэсэг. Би сая байхгүй байсан та нар ярьчихсан байна. Ажлын хэсэг байгуулах тухай гээд Их Хурлын тогтоол гаргана гээд хуулийг нь Их Хурал батлаад өгчихсөн. Тэгээд энийгээ хэрэгжүүлэх нь ЗГ-ын ажил, яамны ажил шүү дээ. Хэрвээ шаардлагатай болбол тэр засаг дээрээ юм уу, яаман дээрээ тэр хууль хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөөгөө батлаад, ингээд хэрэгжүүлэхгүй, гүйцэтгэх засаглалынхаа ажил руу оролцоод Их Хурал дээр ингээд ийм хууль хэрэгжүүлэх хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулна эд нар гээд ийм Их Хурлын тогтоол оруулж ирээд ингээд Байнгын хороон дээр гишүүдийн хооронд бас хэрүүл маргаан болгоод байж болохгүй шүү дээ. Байнгын хороо бас оролцох юмандаа оролцдог, оролцохгүй юмандаа оролцохгүй байхгүй болбол бас болохгүй. Энийг.../минут дуусав/

Б.Баярсайхан: Чинзориг сайдын асуултад хариулахад, 2 номер хариулаад, тэгээд би бас хэлчихье. Саяын хэлэлцэх асуудлын жагсаалтаас 2 дугаар асуудлыг хасчихсан байгаа. Чинзориг сайд өөрөө өөр хуралд орчихсон байсан учраас мэдээгүй байна. Ингээд нэмж асуусан асуултад Ням-Очир дарга хариулъя.

Т.Ням-Очир: Тийм 1 дүгээр ээлжийн 2 сумын 7 объектыг 4 дүгээр ээлж рүү татаад зураг төсөв хийгдэж байгаа. Одоо магадлал хийгдээд гараад ирэх юм бол 4 дүгээр ээлж рүү ажлуудтайгаа зэрэгцээд явахаар байгаа. Тэгэхээр 24 оны эхний хагас жилд багтаагаад бид нар дуусгах арга хэмжээ авна.

Б.Баярсайхан: Надад бас гишүүний хувиар хэд хэдэн асуулт байна. 22 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн Байнгын хорооны 1 дүгээр тогтоолоор ажил эрчимжүүлэх талаар ЗГ-т үүрэг чиглэл өгсөн. Тухайлбал тэр үед бид нар 22 оны 4 дүгээр сард багтаан энэ ариун цэврийн байгууламжийн зураг төслийн ажлыг боловруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж бүрэн дуусгана гэсэн. Тэгээд энэ ажил дахиад л гүйцэтгэл муутай явж байна. Энэ Байнгын хорооны тогтоолтой ажил.

2 дугаарт ЗГ-ын 2023 оны 266 дугаар тогтоолоор стандартын шаардлага хангасан орчин үеийн ариун

цэврийн байгууламжаар солих төсөл арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, 24 оны эхний хагас жилд багтаан дуусга гэсэн чиглэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгаланд өгсөн. Тэгэхээр яг одоо энэ хугацаандаа бүрэн чанартай хийгдэж дуусах уу, яг дуусах уу гэсэн энэ асуулт байна.

Мөн энэ хариуцсан аймаг, сумдын Засаг дарга нарын дарга нар гүйцэтгэлд яаж анхаарч хяналт тавьж ажиллаж байгаа вэ? Та нар яаж хамтран ажиллаж байгаа вэ? Энийг бол та нарын нэг ийм ажиллахгүй байна гэсэн гомдол бол сонсохыг хүсэхгүй байна. Ялангуяа яам, Боловсролын ерөнхий газар өөрөө 21 аймагт энэ Боловсролын газартайгаа, Засаг дарга нартайгаа хамтарч ажиллах бүрэн эрх тэр босоо эрх нь байж байгаа. Тэгэхээр энэ асуултад бас хариулж өгөөч.

Мөн Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд төсөв санхүүгийн мөнгийг шийдүүлээд дахиад 100 тэрбум төгрөг дээр 60 тэрбум төгрөгийг нэмж, Эрдэнэт үйлдвэрээр санхүүжүүлэхээр болсон. Тийм, болсон байна. Яг энэ төсөв мөнгө бол хангалттай гэж бодож байна. Тэгэхээр би ноднин жил ажлын хэсгийн хурал дээр Ням-Очир даргад нэг үүрэг чиглэл өгсөн. Ямар үүрэг чиглэл гэхээр эхний 1, 2 дугаар зарлагдчихсан 1, 2 дугаар ээлжийн асуудал бол ингээд өнгөрчихсөн. 3, 4 дүгээр ээлжийн ажил дээр хэрвээ тухайн сумын эмнэлгийн эмнэлэг нь сумын эмнэлэг нь ойрхон байвал дунд нь хийж байгаа дотуур байр, цэцэрлэг, сургуулиа холбосон энэ дэд бүтцээ сумынхаа эмнэлэгтэй дараа нь гүйцэтгэх ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар Монгол Улсад 220 сумын эмнэлэг гадаа жорлонтой байгаа. Тэгэхээр энэ дэд бүтцээ нэгэнт бас ингээд сумын л асуудал юм чинь бид нар мөнгө төгрөгөө гаргаад зарцуулж л байгаа юм чинь энэ дэд бүтцийн асуудлыг ингэж шийдэх үү гэдэг энэ шийдээрэй, шийдэж болох боломж байна

уу гэдэг энэ асуултыг тавьж байсан. Энэ ажил ямар хүрээнд явагдаж байна вэ?

Дараагийн асуулт Завхан аймгийн Баянтэс сумд сумын сургууль шатааж, ариун цэврийн байгууламжийн шахуурга, ариун цэврийн байгууламж шатсан байгаа. Тэгэхээр өвөл энэ шөнөдөө бараг -50 хэм хүйтэрч байгаа, өвөлжилт хүндэрчихсэн байгаа энэ Баянтэс сумын хүүхдүүдийн хувьд энэ хэдхэн сарын хугацаанд дотуур байрандаа дулаан халуун устай, дотроо жорлонтой ийм сайн хэрэглээнд дассан. Сая намайг томилолтоор очиход бол хүүхдүүд нь уйлж байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэх, түргэн хугацаанд шийдвэрлэх ямар боломж байна вэ гэдгийг асууя.

Чанарын асуудал сая Алтанхуяг инженерт би хэллээ. Эцсийн эцэст та нар өнөөдөр 22 онд дуусгах ажлаа 24 он гарчихсан байхдаа ярихдаа эхний ажил ингээж эхэлсэн гэдэг яриагаа бүрэн зогсоохыг хүсэж байна. Боловсролын ерөнхий газар өөрсдөө үнэлгээний хороогоо байгуулаад энэ худалдан авах ажиллагааг хариуцаж байгаа юм байна. Тийм учраас Ням-Очир дарга та үнэлгээний хороондоо итгэмжтэй хүмүүсийг сонгон ажиллуулж байгаа юу, танай үнэлгээний хороо хэр чадамжтай ажиллаж байгаа вэ? Ямар нэгэн ашиг сонирхолгүйгээр энэ тендерийг зохион байгуулж чадаж байгаа юу гэсэн энэ асуултаудад хариулт авъя. Энх-Амгалан сайд эхний асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Эхний 2 асуултад нь би хариулчихъя Ням-Очир даргаа. Тэгээд сүүлийн 3, 4 дүгээр асуултад нь та хариулчхаарай. Ерөнхийдөө энэ ариун цэврийн байгууламжууд Монгол Улсын 330 сумд хэрэгжиж байгаа, нийт 820 орчим объектууд сургууль, цэцэрлэг, дотуур байруудыг холбох ажлууд хийж байгаа учраас яг хэрэгжилтийн явцад болбол үнэхээр хүндрэлүүд байх нь байгаа. Гэхдээ энэ дээр шалтаг тооцохгүй. Энэ

ЗГ-ын түрүүн тогтоолын та нөгөө хугацааг дурдаж ярьж байх шиг байна 24 оны 1 дүгээр улирал гэж. Тийм учраас бол бид нар ямар ч байсан энэ 24 оны 9 сарын 1 гэхэд болбол бүх сургууль, цэцэрлэг, дотуур байруудынхаа энэ ариун цэврийн байгууламжуудыг л бүрэн ашиглалтад өгөх ийм бололцоо бид нарт байгаа. Энийг бас би хариуцлагатайгаар мэдэгдье. Нэг бус удаа би Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороон дээр бас салбарын сайдын хувьд бол энэ хариуцлагатай мэдэгдэл хийж байсан учраас энэнийхээ хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл рүү өөрөөс шалтгаалсан бүх зүйлүүдийг хийнэ гэж бодож байна.

2 дахь асуудал болбол тэр эрүүл мэнд нөгөө сум дээр байгаа эмнэлгүүдтэй холбоотой асуудал байгаа юм Баярсайхан гишүүнээ. Энийг бид нар бас ярьсан. Яах вэ Байнгын хорооны тогтоол дээр ч гэсэн бас тийм заалтууд байгаад байгаа юм. Тэгэхээр наад чинь уг нь болбол хорин би буруу санаагүй болбол 22 оны Эрүүл мэндийн сайдын сайдын багц дээр 60, 70-аад тэрбум төгрөг бас энэ ариун цэврийн байгууламжтай болох асуудлууд тусгагдсан юм байна лээ. Гэхдээ энд чинь хэрэгжээд хэрэгжилт байхгүй байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ Азийн хөгжлийн банкны бас нэг судалгаагаар манай Барилга, хот байгуулалтын яамны хийсэн судалгаагаар би буруу ярьж байгаа болбол бас зөв зөвтгөж хэлээрэй тоонуудыг. Нэг 50-аас 70-аад сумуудын нөгөө дэд бүтцийн нэгдсэн нэг дэд бүтэцтэй болгоё гэдэг нэг судалгаанууд хийгдээд, ТЭЗҮ-үүд нь боловсруулагдаад энэ төсөл үргэлжилж ингэж явж байгаа гэж би ойлгож байгаа. Тэгэхээр энийг бид нар яваандаа болбол үндсэндээ болбол ийм нэгдсэн ийм бохирын, хэрэв сум дээр ингээд сургууль нь тусдаа, эмнэлэг нь тусдаа, захиргаа нь тусдаа ийм байж болохгүй л дээ. Нэгдсэн ийм шийдлүүд л ярих ёстой гэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр манайхны нэмж хийж байгаа, манай зөвлөх инженер тэнд сууж байх шиг байна. Нэмж хийж байгаа асуудлууд болбол бид нар хэрэв энэ сумын нэгдсэн халаалтын нэгдсэн, бохирын асуудлууд, эрүүл мэндийн нэгдсэн бохирын асуудлыг хүлээх юм болбол дахиад л хугацаа алдана, дахиад л хугацаа алдана. Тийм учраас одоо бид нарт бид нар 2 боломж гаргаж өгч байгаа гэж би ойлгож байгаа. Хэрэв үнэхээр ойрхон байгаа, тэгэхдээ энэ чинь ачааллаас бас шалтгаална шүү дээ. Нөгөө сурагчийн тоо, тэр ариун цэврийн байгууламжийн өөрийнх нь нөгөө боловсруулах ачааллаас шалтгаалах учраас ойрхон байгаа эмнэлгүүдүүдийг болбол хэрэв санхүүжилт нь холбох санхүүжилт нь байвал тэрийг техникийн хувьд болбол холбочиход би асуудалгүй гэж ойлгож байгаа тийм ээ.

2 дугаар асуудал болбол тэр эмнэлгүүдийн асуудал болбол энэ сумууд дээр хийгдэж байгаа дэд бүтэцтэй холбогдож хийгдэх учраас бид нар хэрэв өнөөдрийн байдлаар таны өгсөн чиглэлийн дагуу тэр АХБ-ны сум дээр хэрэгжиж байгаа тэр бохирын байгууламжийн төсөл, дахиад эрүүл мэндийн салбарынхан дээр тавигдсан хийгдэж байгаа ажлуудтай бүгдийг нь уялдуулж ажиллана гэх юм бол дахиад л тодорхой сумууд дээр ажил хойшилох л ийм нөхцөл байдал үүсэх юм байна лээ. Тийм учраас бид нар ерөөсөө зүтгээд л өөрсдийнхөө хийсэн ажлуудыг дуусгаад, цаг хугацаанд нь дуусгах л нэг ийм л тактик баримталж ажиллаж байгаа гэдгийг бас би хэлье гэж бодож байна. Энийг бас бид нар яриагүй биш ярьсан юм, дотроо хэд хэдэн шийдлүүд ярьсан юм. Бусад тэр Завханы юутай холбоотой Баярсайхан гишүүний тэр нөгөө үнэлгээний хороотой холбоотой асуудал дээр Ням-Очир дарга хариулт өгчих.

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Т.Ням-Очир: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хуулийн тухай хуулийн дагуу яг энэ ариун цэврийн байгууламжтай холбоотой үнэлгээний хороо Боловсролын ерөнхий газар дээр байгуулагдаж байгаа. Худалдан авах ажиллагааныхаа хуульд холбогдох дүрэм журмын дагуу бүх тендер зохион байгуулах үйл ажиллагаа бол цахимаар зохион байгуулагдаж байгаа. Яг зүгээр өнөөдөр бол бид нар эхний батлагдсан 100 тэрбумынхаа хүрээнд бүх худалдан авах ажиллагаагаа зарлачихсан. Одоо нэмэлтээр батлагдсан 60-ынхаа хүрээнд бол худалдан авах ажиллагаанууд эхнээсээ зарлагдаад эхэлсэн ингээд явж байгаа. Энэтэй холбоотойгоор ямар тендер сонгон шалгаруулалттай холбоотой гомдол гарч, ажил удааширч, хойшилсон зүйл одоогоор бол байхгүй байгаа. Аль болох хариуцлагатай, цаг хугацаанд нь зарлах, өмнөх худалдан авах ажиллагаанууд дээр шалгарч орж ирсэн сайн гүйцэтгэлтэй компаниуддаа бас ямар нэг байдлаар мэдээлэл өгч, дахин орох энэ боломж нөхцөлийг нь хууль тогтоомжийн хүрээнд хангах энэ чиглэлээр бас бид нар сайдын шуурхай дээр яригдаж, энэ чиглэлээр бас анхаарч ажиллаж байгааг бас хэлэх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна.

Завхан аймгийн Баянтэс сумын хүрээнд бол сургуулийн удирдлагуудтай бид нар холбогдож, шаардлагатай ширээ, сандал, гал тогооны тоног төхөөрөмжийг бол хүсэлтийнх нь дагуу бас зохион байгуулж нийлүүлсэн. Яг энэ ариун цэврийн байгууламжийн шавхаргатай холбоотой юмыг бид нар орон нутгийн удирдлагуудтай холбогдож шийдэхээр ярилцсан байгаа. Ашиг сонирхлын зөрчил байхгүй, чадамжтай ажиллаж байгаа гэж үзэж байгаа.

Б.Баярсайхан: Ням-Очир даргаа тодруулъя би. Энэ 1 дүгээрт Барилгын

хөгжлийн төв зураг төсвийг Барилгын хөгжлийн төвөөс хийж байгаа тийм ээ. Барилгын хөгжлийн төвийн зураг төсөв хэр чанартай гарч байгаа юм, хэр маш сайн зураг төсөв гарч байгаа юм энийг тодруулж асууя.

2 дугаарт танд гомдол ирээгүй гээд байх юм. Та энэ сумуудаар өөрөө явж ажиллахгүй байгаа болохоор мэдэхгүй байх шиг байна. Би өөрөө Завхан аймаг руу явахдаа наана нь ингээд замд тааралдсан аймгуудынхаа сумдын ариун цэврийн байгууламжийг шалгаад явчихдаг. Жишээлбэл сая намар намайг Завхан явж байх замд би Архангай аймгийн Хотонт сумд хийгдсэн ямар ч чанаргүй, тэгээд тэр жорлонгийн суултуур байхгүй, түгжээ байхгүй, энэ хаалганууд нь суултуур дээрээ суунгуут хүний толгой хаалган дээрээ тулаад сууж болдоггүй ийм стандартын бус ариун цэврийн байгууламжууд баригдаад байхад та энийг гомдол гараагүй гэж яриад байх юм. Ингээд тэнд шалгалт хийж очоод гүйцэтгэсэн байгууллага нь хүрч ирээд ямар ч асуудалгүй энэ болгоныгоо засаад өгчхөж байна лээ. Тэгэхээр энэ гомдол ирээгүй гэдгээ боль л доо. Өөрөө одоо ажиллаад яв, 2 сарын 15-наас авхуулаад энэ орон нутгаар би дэд ажлын хэсгийн даргатайгаа хамт энэ ажлыг бас шалгаж явмаар байна. Тэгэхээр гомдол ирээгүй гээд суугаад байж болохгүй байна.

Тийм учраас та нарыг энэ аймгийнхаа Засаг дарга нартай хэр ажиллаж байгаа юм бэ гэдэг зүйлийг асуугаад байна шүү дээ. Боловсролын ерөнхий газар луу зориг гаргаж, сургуулийн захирал манайх энэ болохгүй байна гэж хэлэх хөдөө орон нутгийн багш нарт бас тийм асуудал байж, байдаггүй юм байна лээ. Тэгээд л тэрүүхэндээ нэг асуудлаа яриад байгаад байна уу гэхээс биш, шууд зоригтой гомдлоо гаргачихдаг бас нэг тийм сургуулийн захирал, сумын Засаг дарга нар чинь ховор юм байна лээ шүү дээ. Тийм учраас та гомдол хүлээж

суумааргүй байна. Чанарын асуудал янз бүр байгаа. Энэ дээр нэг хариулт өг дөө.

Т.Ням-Очир: Гишүүнээ би нөгөө үнэлгээний хорооны сонгон шалгаруулалттай холбоотой гомдол ирээгүй гэж хариулт өгсөн. Тэгээд яг ашиглалттай холбоотой бол ариун цэврийн өрөөнд нолын цаас байхгүй ч юм уу, бөглөрчихлөө ч гэдэг юм уу, хэт хүйтрэл гараад тог тасраад байна гэдэг ч юм уу, гүйцэтгэгч компани энийгээ дутуу хийчихлээ гэдэг ийм асуудлууд бол ирээд бид нар яг дор бүр нь бас залруулаад явж байгаа гэдгийг бас онцолж хэлье. Тэгээд нэгж байгууллага дээр бол бид нар орон нутгийн томилолттой үеэр ариун цэврийн байгууламжаа бол давхар хянаад явдаг. Тэгээд яг энэ зураг төсөв чанартай хийгдэж байгаа энэ асуудал дээр бас манай зөвлөх инженер бас нэг тодруулга хариулт өгч болох болов уу? Зөвлөх инженерийн хувьд, Цэрмаа инженер.

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон инженер Цэрмаа.

Г.Цэрмаа: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Эхний ээлжид би тэр түрүүчийн эмнэлгийн байгууллагын инженерийн энэ дэд бүтэцтэй нь холбох гэдэг асуудал дээр нэг товчхон хариу өгье гэж бодож байна. Энэ ариун цэврийн байгууламжийн бохирын асуудлыг зөвх асуудал маань яадаг вэ гэхээр тэр цэвэрлэх байгууламж 12м³-ээс илүү давсан тохиолдолд сумын төвөөс гадагшаа гарах гэдэг гэдэг заалттай байдаг учраас сургууль, цэцэрлэг, дотуур эмнэлэг 3 нийлчхээрэй ер нь л бараг сургууль, дотуур байр 2 ч юм уу нийлэхээрээ л ер нь 12 кубээс даваад явчхаж байгаа юм. Тийм болохоороо нормоороо болохгүй байгаа. Энэ дээрээс юуг анхаарч байгаа вэ гэхээр зэрэг ерөнхийдөө сумуудад Сумын хөгжил гэсэн төсөл хэрэгжээд БХБЯ-наас нөгөө ерөнхийд нь төвийн бохиртой болгох, дулаантай болгох, цэвэр устай болгох гэсэн асуудлууд байгаа. Ингэсэн

тохиолдолд болбол бүгдээрээ нийлээд нэгдэж боломжтой болоод байгаа. Энэний хувьд ийм учраас эмнэлгийг холбож болохгүй байгаа.

Тэр Завханы Тэсийн хувьд болохоор зэрэг би холбогдсон, гүйцэтгэгчтэй нь холбогдсон. Тэд нар төсвөө хийлгээд авчихсан байсан. Тэгээд тэр шатсан сургуулийн гадна дэд бүтцийг одоо уг нь болбол нөгөө тусдаа уурын зууханд байж байгаад л шатчихсан нь эрсдэл үүсгээд байгаа болохоос нөгөө байгууламж дотор нь байгаа усаа зөөх болчхож байгаа, энэний шугамын асуудлыг хийе гэсэн. Энийгээ яриад сум, аймаг 2 өөрсдийн нөөц хөрөнгөөрөө хийнэ гэж шийдвэрлэсэн учраас наашаа асуудал тавихгүй гэсэн.

Зургийн чанарын хувьд болбол түрүүчийн тэр Архангай Хотон сум гээд тэгж байгаа. Яг таныг явж байх үед тийм процесс болсон нь үнэн. Тэр ямар учиртай юм бэ гээд тэгэхээр нөгөө 1, 2 дугаар ээлж чинь гүйцэтгэгч нар нь түлхүүр гардуулах нөхцөлөөр авчхаад, өөрсдөө тэрэндээ судалгаа хийгээд, зургаа оруулсан юм байна лээ. Тэгээд магадлалаар гаргаж ирэхдээ яг таны очсон тэр сум дээр яасан гэхээр угаасаа тэр ариун цэврийн байгууламжтай сум байсан. Тэгэхдээ дотроо нөгөө жорлон нь тоногдчихсон иймэрхүү хагас байсан учраас төсөвт нь аваачаад хагас хийхээр оруулчихсан. Угаасаа мэдээж шинэ төсөл явж байхад юмыг нь хагасалчхаад тэр хүний нүдэнд угаасаа аятайхан харагдахгүй ингээд л нөгөө дутуу, дутуу хийчихсэн юм шиг харагдсан байсан. Тэгэхдээ энэ дээрээс яах вэ дээ зүгээр завсарт нь нэг юм хавчуулж хэлэхэд гүйцэтгэгч компанийн хувьд болбол Барилгын хөгжлийн төвөөс ч, манайхаас ч гэсэн иймэрхүү байна гэдэг шаардлагыг тавиад нэгэнт дутуу учраас та нар м... ажлын зардал ямар нэгэн нөөцөөрөө энийг гүйцээж хийхгүй бол та нарын хийсэн юм хоёрын хооронд хийсэн ч юм шиг, хийгээгүй ч юм шиг ийм муухай харагдана гэдэг шаардлагыг тавихад

хүлээгээгүй мөртөөсөө харин таныг очоод л дуудсан чинь долоо хоногийн дотор хийсэн. Тэр жоохон онцгүй байсан. Нэг тийм юм болсон. Дараагийн тэр ажлын зураг дээр, яах вэ дээ хүмүүсийн нөгөө нэг харьцаж байгаа өнцөг л байхгүй юу. Гишүүн очихоор аймаар дуулгавартай хийчхээд, эндээс зөндөө олон төрийн албан хаагч нар хэлж байхад аягүй хэцүү байсан. Тэр жоохон онцгүй санагдсан.

Дараагийн дугаарт нь тэр ажлын зураг чанартай болж байна уу, чанаргүй болж байна уу гэдэг дээрээс би 1, 2 дугаар ээлжийн ажлын зураг дээр үнэндээ сүүл рүү нь орж ирээд, дундаас нь явсан болохоор яг сайн магадлан хэлж чадахгүй, ямар ч байсан ажлыг нь сайн гүйцэтгүүлэхийн төлөө шаардлага тавьж байгаа. 3, 4 дүгээр ээлжийн зургийг болбол би яг өөрөө хариуцаж байгаа. Тэгэхдээ яадаг вэ гэхээр зэрэг би магадлал хийх нь Барилгын хөгжлийн төв. Хийх үед тухайн объект дээр юм хоцроохгүй гэдэг үүднээс зургийн байгууллагууд шалгараад гараад ирэхээр тэд нар хөдөө орон нутаг яваад судалгаа хийгээд ирэхээр би сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчтэй нэг бүрчлэн холбогддог. Энэ очсон компани чамайг танайхыг ингээж судалсан байна шүү, энэ чинь үнэн үү, эд нар худлаа ярьж байна уу, юу чинь орхигдож байна, юу чинь болох гээд байна гээд бараг сургуулийн захирал, эрхлэгч нарыг залхтал ярьдаг. Тэгээд ийм байдлаар энэ нь тэгвэл яг үнэн юм байна, одоо тэгвэл та нар ингээд зургаа хийгээрэй гэдэг юмаараа явж байгаа. Зүгээр зураг хийгээд магадлалд ороход бол мэдээж тэд нар би хэдий эрхлэгч, захиралтай нь зөв болгоод ингээд хэлээд өгөөд явуулахаар, одоо тэд нар мэдээж зургийн байгууллага чинь тооцоо хийнэ, үндэслэл гарна, к...-аар зурна гээд зөндөө процесс цаашаа явагдана шүү дээ. Тэр хэмжээ дээр нь ирэхгүй.../минут дуусав/

Б.Баярсайхан: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асууж

дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Би ажлын хэсгийн ахлагчийн хувьд мөн Байнгын хорооны даргын хувьд, гишүүний хувьд хэдэн санал хэлье. Ер нь бол өнөөдөр дэд ажлын хэсгийн ажлын гүйцэтгэл бол төдийлөн хангалттай биш гэж ингэж харагдаж байгаа. Дараа дараагийн ээлжид тавхан сар үлдсэн байна. Энэ 3 жилийн өмнөх асуудлыг юм уу яриад нөгөө л ярьдаг асуудлаа яриад орж ирмээргүй байна ажлын хэсгийн, дэд ажлын хэсгийн гишүүдээ. Тийм учраас энэ хэрэгжилтийг хангах, чанартай гүйцэтгэх тал дээр анхаарах, онцгой анхаарч ажиллах энэ чиглэлийг өгч байна санал.

Мөн энэ зураг төсвийг чанартай хийж, үлдсэн энэ ажлуудаа яаралтай батлуулж, ажлаа шуурхайлах энэ ийм саналтай байна. Мөн санхүүжилтийг хууль тогтоомжийн хүрээнд олгож, шуурхай бас ажиллах, гүйцэтгэгч компанийг хянахаас гадна тэднийг бас хохиролгүй энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд бас туслан ингэж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Боловсрол, шинжлэх ухаан, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарт төслийн ажилд анхаарлаа хандуулах зөвлөмж чиглэлийг өгч байгаа. Тэгэхээр энэ ирэх долоо хоногт гэхэд бүх аймгийн Засаг дарга нар ЗГ-тай гэрээ байгуулах энэ ажил хийгдэх гэж байна. Тэгэхээр дэд ажлын хэсгийг, даргыг Боловсролын ерөнхий газрын дарга мөн салбарын сайд ч гэсэн энэ аймгийн Засаг дарга нартай яг энэ гэрээ хийхдээ онцгойлон энэ ариун цэврийн байгууламжийн асуудлыг ярьж, тэдний энэ ажлыг дүгнэх, ер нь бол орчихсон юм шүү дээ. Энэ 23 оны Засаг дарга нарын ажлыг гүйцэтгэхэд тухайн орон нутагт ариун цэврийн байгууламж хэрхэн чанартай, үр дүнтэй гүйцэтгэсэн талаар тухайн Засаг дарга нарын ажлыг үнэлнэ гээд ингээд орчихсон байгаа. Тэгэхээр энэ асуудлыг дахин уулзаж, Засаг дарга нараас бас мэдээлэл авч,

ажлын хэсэгт, Байнгын хороонд буцан танилцуулах ийм бас чиглэл өгье.

Сая Цэрмаа инженерийн хэлээд байгаа тэр Баянтэс сумын асуудлыг ойлголоо. Би Тэс сумд бас сая ажилласан байгаа. Тэгэхээр Тэс сумын сургуулийн ариун цэврийн байгууламж төдийлөн бас чанартай биш. Яг одоо хэлж байгаа нь суултуур хаалга 2-ыг тулгаж барьсан учраас хүн суугаад тонгойход толгой нь тулчихаад, хаалгаа онгойлж бие засах ийм хэмжээнд оччихоод байгаа юм. Тэгээд ийм хөгийн, ийм ичмээр юм хийхээ болио. Ийм зүйл гүйцэтгэж байгаа компаниудтайгаа хариуцлага тооц, тэр хар жагсаалтад оруулмаар байвал Сангийн яамтай яриулаад, дахиад ийм компаниудыг шалгаруулсан алдаагаа та нар өөрсдөө зас, өөрсдөө л зас. Энэ асуудлыг би бүүр онцгойлон хэллээ шүү.

Ариун цэврийн байгууламж барих төслийн ажилд хариуцлага алдсан албан хаагчдад зохих хариуцлага тооцох арга хэмжээ авах энэ ажил бол заавал явагдах ёстой. Энд ирэх 5 сарын ажлын дараалал, танилцуулга, календарьчилсан төлөвлөгөөгөө баталж, мөн ажлын хэсэгт, Байнгын хороонд энийгээ явуул гэж. Ажил тасалдуулж, хугацаа алдах нөхцөл байдал үүсгэхгүй байдлаар энэ ажлаа зохион байгуулах, хариуцсан яамнууд үйл ажиллагаагаа уялдуулж, дахин энэ ажлаа шуурхайлан арга хэмжээ авах, төсвийг объект нэг бүрээр гаргах ийм чиглэлийг өгмөөр байна. Яагаад гэвэл би олон удаа хэлж байгаа. Бид нар говь, хангай тийм ээ, хангайн бүс, говийн бүс, тал, тэгээд уур амьсгалын хувьд, байгаль тогтцын хувьд янз бүрийн ийм аймаг, сумуудад үйл ажиллагаа явуулж байгаа учраас объект нэг бүрийг нэг бүрчлэн зураг гаргаж, объект нэг бүрээр тухайн аймгийн орон нутгийн цаг агаар, газар нутгийн байдал тэр асуудалтай холбоотойгоор ажлаа чанартай гүйцэтгэх.

Чанаргүй хийгдсэн ариун цэврийн байгууламжийг эргэж хянаж, алдаагаа

засах. Хэрвээ боломжтой бол энэ 100 жилээ тэмдэглэж байгаа аймгууд, сумуудын асуудлыг бас түрүүлж дуусгах ийм боломж гаргаж өгөөч. Яагаад гэвэл 100 жилээ тэмдэглээд л байх юм, 90 жилээ тэмдэглээд л байх юм сумууд. Ариун цэврийн байгууламж байхгүй, модон жорлон хэрэглэсэн хэвээрээ юм байна.

Мөн энэ ариун цэврийн байгууламж баригдчихсан сумуудад энэ модон жорлонг устгах, модон жорлонг байхгүй болгох ийм ажлыг хийхгүй бол жоохон дулаан орохоор тухайн дотуур байрны багш, үйлчлэгч нар хүүхдүүдийг одоо дотроо битгий бие засаад бай олноороо, гадагшаа гарч модон жорлонд бие зас гэдэг ийм асуудал бодитойгоор гарч байгаа гэдгийг орон нутагт ажиллаж явж байхдаа яг нэртэй устай, сумтай, сургуультай, захиралтай нь ингээд бид нар харж байсан. Тийм учраас 1 дүгээрт бид нар чанартай хийчих юм бол модон жорлонг устгачихад асуудал байхгүй. Тэгэхээр энэ модон жорлонгоос салах гэж байгаа болбол газрын хөрснөөс тэр модон жорлонгоо арчин хаях хэрэгтэй байна. Энэ асуудлуудыг ингэж хийгээрэй.

Тэгээд ойрын хугацаанд хийгдэх ажил надад төлөвлөгөө танилцуулах юм байна. Аймгийн Засаг дарга нартаа ажлаа дахин сануулаад, 23 оны энэ аймгийн Засаг дарга нарын ажилд үнэлэлт дүгнэлт өгөхөд ариун цэврийн байгууламжийн бүтээн байгуулалт ямар байсан юм бэ гэдэг талаар бас мэдээлэл өгөөрэй гэж хүсье. Ингээд ажлын хэсгийн гишүүдэд амжилт хүсье. Бидний хийж байгаа ажил болбол дахиад хэлье. Монгол Улсын хувьд анх удаа хийгдэж байгаа, жинхэнэ хөгжил дэвшил гэдэг бол жорлонгоос эхэлнэ. Тэгэхээр 6-аас 16, 7 настай нялх балчир хүүхдүүд өвлийн хүйтэн, хаврын сэрүүн, намрын шуурганд 200 метрт байрлах модон жорлонд бие засах энэ асуудлыг халах, энэ хөгжлийн хувьсгалыг хийж байгаа, гардан хийж байгаа хүмүүс та нар. Тийм учраас хийж

байгаа ажилдаа эцэг, эхийн хайраар, мөн төрийн албан хаагчдын хариуцлагатайгаар энэ ажлаа бүрэн чанартайгаар хийж гүйцэтгээрэй гэдэг энэ сануулгыг, энэ хүсэлтийг та бүхэнд тавьж байна. Тэгээд амжилт хүсье.

11.06 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан үүгээр дуусаж байна.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

